



ХӨЛ ХОРИО БА ЭХ ОРОНДОО ИРЭХ ЭРХ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Л.Амгаланбаатар (LL.M.)

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан

Х.Норовсүрэн

АКР хуулийн фирмд хуульчийн туслах

Улаанбаатар хот
2021 он

ННА 673
ДАА 340.009
А-524



ХӨЛ ХОРИО БА ЭХ ОРОНДОО ИРЭХ ЭРХ

Судалгааны тайлан

Л.Амгаланбаатар (LL.M.)

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Х.Норовсүрэн

АКР хуулийн фирмд хуульчийн туслах

Судалгааны хүрээнд гаргасан дүгнэлт, санал нь судлаачийн үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форум болон бусад байгууллагын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9645-6-6

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240

Утас: 976-76113207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ	5
1.1 Судлагдсан байдал	6
1.2 Судалгааны зорилт	6
1.3 Судалгааны хүрээ, арга зүй	7
ХОЁР. ЭХ ОРОНDOO БУЦАЖ ИРЭХ ЭРХИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ	8
2.1 Эх орондоо буцаж ирэх эрхийн хууль зүйн ойлголт	8
2.2 Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан байдал	9
2.2.1 Хүний эрхийн түгээмэл тунхаглал	9
2.2.2 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	10
2.2.3 Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	15
2.2.4 Хүүхдийн эрхийн тухай конвенц	16
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ, ХЯЗГААРЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА	18
3.1 Монгол Улсын Үндсэн хууль ба бусад хууль тогтоомжид заасан шаардлага	18
3.2 Ковид-19 хууль ба бусад хууль тогтоомжийн шаардлага	20
3.2.1 Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх	23
3.2.2 Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх	24
3.2.3 Дээрх зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх	25
3.2.4 Энэ хуульд заасан арга хэмжээ нь тухайн нөхцөлд тохирсон тодорхой хамрах хүрээ, хугацаатай байх	26

3.2.5	Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх	28
3.2.6	Цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан, бодитой, тохирсон байх	29

**ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГАДААД УЛСАД БАЙГАА ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН
БОДЛОГО БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ**

4.1	Монгол Улсын Засгийн газар, УОК-ын шийдвэр, арга хэмжээ	31
4.1.1	Гадаадад байгаа иргэдийг авч ирэх ажиллагаатай холбоотой шийдвэр, арга хэмжээ	35
4.1.2	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах тусгай сангийн зориулалт, хэрэгжилт	37
4.2	Монгол Улсаас Гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Консулын газраас гадаадад байгаа иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээ	42
4.3	Явцын дүгнэлт	44

ТАВ. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

5.1	Европын холбооны туршлага	45
5.2	Япон Улсын туршлага	46

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ

6.1	Дүгнэлт	50
6.2	Санал	51

НОМ ЗҮЙ

ХАВСРАЛТ

НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсад хэрэгжиж буй хилийн хоригийн үр дүнд гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн “эх орондоо буцаж ирэх” үндсэн эрх зөрчигдсөн эсэх талаар нийгэм, олон нийтийн дунд хэлэлцүүлэг, маргаан өрнөсөөр байна. Энэ цаг үед гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн “эх орондоо буцаж ирэх” үндсэн эрх зөрчигдөж байгаа эсэхийг холбогдох хууль тогтоомжийн үндэслэл, шаардлагын хүрээнд нарийвчлан авч үзэж судлах нь тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд тус дэм болох юм. Тэрчлэн, энэхүү судалгааны үр дүнгээр дамжуулан эх орондоо буцаж ирэх эрхийн мөн чанар, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах чухал ач холбогдолтой.

Энэхүү судалгааны хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан Монгол Улсын иргэний “эх орондоо буцаж ирэх” үндсэн эрхийн талаар авч үзлээ. Түүний дотор “Ковид-19” цар тахлын онцгой үед хэрэгжиж буй дотоодын хууль, тогтоомжид хүний эрхийн хязгаарлалт, түүнд тавигдах шаардлага, үндэслэлийн талаар хэрхэн зааж тусгасныг дэлгэрэнгүй авч үзэж, бодит байдалд энэхүү шаардлага, үндэслэлүүд нь хангагдаж байгаа эсэхийг үнэлж, дүгнэх зорилго тавьж ажиллав. Тухайлбал, Монгол Улсад “Ковид-19” цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоогоод буй хилийн хориг, түүний хэрэгжилт нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенц, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.9, 10.10 дугаар зүйл, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан хүний эрхийн хязгаарлалтад тавигдах нийтлэг шаардлага, үндэслэлийг хангаж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Мөн дотооддоо “Ковид-19” цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хилийн хориг, энэ талаар зааж тусгасан хууль тогтоомжийн үндэслэл, түүний хэрэгжилтийн байдлыг хөндлөнгөөс үнэлж, дүгнэх үүднээс Япон Улс болон Европын холбооноос “Ковид 19” цар тахлын дэгдэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн хилийн хоригийн арга хэмжээ,

таган авах ажиллагаа, түүнтэй холбоотой шийдвэр, туршлагыг харьцуулан судалсан болно.

1.1 Сэдвийн судлагдсан байдал

Энэ сэдвийн хүрээнд гарсан дотоодын сүүлийн үеийн судалгаанаас үзвэл, О.Мөнхсайхан “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт” Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, 2017 он, өнөөдөр сонинд нийтлүүлсэн “Хүний эрхийг хязгаарлах бол тодорхой шалгуурыг хангах ёстой” сэдэвт ярилцлага, Г.Нарантуяа “Гадаадад гацсан Монголчууд: Монгол Улсын Засгийн газар олон улсын эрх зүйн үүргээ зөрчсөн үү?” нийтлэл болон *SnowHill Consultancy LLP*-ийн 2020 оны 8 дугаар сард Улсын онцгой комисс (УОК гэх)-т хүргүүлсэн “Монгол Улсын иргэн эх орондоо буцаж ирэх эрхийн тухай” дүгнэлт, зөвлөмж тус тус байна.

1.2 Судалгааны зорилт

Удиртгал хэсэгт дэвшүүлсэн асуудлын хүрээнд дэвшүүлж тавьсан зорилтууд нь:

1. Олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт, олон улсын баримт бичгүүдэд үндэслэн “эх орондоо буцаж ирэх эрх”-ийн үзэл санаа, мөн чанарыг судалж, тус эрхийг хязгаарлах боломж, шаардлагын талаар дэлгэрэнгүй авч үзэх;
2. Монгол Улсын Үндсэн хуульд чөлөөтэй зорчих эрх, түүний дотор “эх орондоо буцаж ирэх эрх”, түүнийг хязгаарлах нөхцөл, журам, үндэслэлийн талаар хэрхэн тусгагдсаныг авч үзэх; мөн Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиудад заасан хүний эрхийг хязгаарлах үндэслэлийг судалж, энэ нь Үндсэн хуульд заасан агуулгатай нийцэж байгаа эсэхийг авч үзэх;
3. Хорио цээрийн дэглэмийн хүрээнд дотооддоо хилийн хориг тогтоосон шийдвэр, арга хэмжээ нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9, 10.10, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр

- зүйд заасан хүний эрхийн хязгаарлалтад тавигдах шаардлага, үндэслэлийг нэг мөр хангаж байгаа эсэх, үүний үр дүнд гадаадад байгаа иргэдийн эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлаж байгаа эсэхийг шалгах;
4. Хилийн хориг тогтоосон шийдвэр хэрэгжих хугацаанд гадаадад байгаа иргэдэд чиглэсэн ямар тусламж, дэмжлэг, арга хэмжээ зохион байгуулсан талаар бодит кэйс, баримтад тулгуурлан дүн шинжилгээ хийх;
 5. Европын холбоо болон Япон Улсаас гадаадад байгаа иргэддээ авч хэрэгжүүлсэн шийдвэр, арга хэмжээний талаарх туршлагыг товч харьцуулж судлах;
 6. Дээрх судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан гадаадад байгаа иргэдийн асуудлыг шийдвэрлэх талаар судлаачийн дүгнэлт, саналыг дэвшүүлэх зэрэг байв.

1.3 Судалгааны хүрээ, арга зүй

Энэхүү судалгаа нь “*Right of return*” буюу “эх орондоо буцаж ирэх” эрхийн олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн суурь ойлголт, зарчим, түүний хязгаарлалтад тавигдах шаардлага, үндэслэлийг хилийн хориг тогтоосон шийдвэр, арга хэмжээний харилцан хамаарлын хүрээнд авч үзнэ. Үүнд (i) “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт заасан “*Right of return*” буюу “эх орондоо буцаж ирэх” эрхийн талаарх ойлголтыг олон улсын эрх зүйн хүрээнд судалж, тус эрхийг хязгаарлахад ямар шалгуур байх ёстой вэ? гэдэг үндсэн асуултад хариулт өгөх ба (ii) энэ нь Монгол Улсын дотоодын хууль тогтоомжид хэрхэн тусгалаа олсныг судалж, Засгийн газраас гаргасан хилийн хориг тогтоосон шийдвэр нь хүний эрхийг хязгаарлахад тавигдах шаардлагыг нэг мөр хангасан эсэх, тухайн шийдвэрийн үр дүнд гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн “эх орондоо буцаж ирэх” зөрчигдсөн эсэхэд дүгнэлт хийж; (iii) Япон Улс болон Европын холбооны туршлагыг харьцуулан судалж, гадаадад байгаа иргэдийнхээ “эх орондоо буцаж ирэх” эрхэд хязгаарлалт хийсэн эсэх асуудлыг чухалчилж авч үзнэ. Энэхүү харьцуулалтын үр дүнд Монгол Улсын хилийн хориг тогтоосон шийдвэр, түүний хэрэгжилттэй холбоотой нийтлэг болон ялгаатай талыг илрүүлж, манай улсын хувьд сайн туршлага болохуйц ойлголт, зарчим, шийдлийг санал болгоно.

ХОЁР. ЭХ ОРОНДОО БУЦАЖ ИРЭХ ЭРХИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Түүхэн талаас авч үзвэл, “эх орондоо буцаж ирэх эрх” нь хамгийн анхны “Эрх чөлөөний баримт бичиг” гэгддэг 1215 оны Магна Хартад анх тусгалаа олсон гэж үздэг¹. Магна Хартын 42 дугаар зүйлд дайны цагаас бусад тохиолдолд аливаа хүн бүр хаант улсаас явах, буцаж эрхтэй болохыг хүлээн зөвшөөрсөн байна².

2.1 Эх орондоо буцаж ирэх эрхийн хууль зүйн ойлголт

Эх орондоо буцаж ирэх эрх нь зорчих эрхийн нэг хэлбэр бөгөөд олон улсын зан заншлын эрх зүйн хүрээнд хэлбэржиж, тайлбарлагдаж ирсэн. Зорчих эрх нь дотоод болон гадаад гэсэн үндсэн хоёр хэлбэртэй байна. Дотоод хэлбэр нь аливаа улсын хил хязгаар дотор зорчих эрхтэй байх тухай агуулгыг илэрхийлэх бол гадаад хэлбэр нь улс хооронд зорчих тухай агуулгыг илэрхийлнэ. Энэ утгаараа эх орондоо буцаж ирэх эрх нь зорчих эрхийн гадаад хэлбэрийг илэрхийлэх бөгөөд энэ нь гадаадад түр болон удаан хугацаагаар эсхүл бүр мөсөн явах, мөн эх орондоо буцаж ирэх гэсэн бүх агуулгыг багтаана³.

Зарим судлаач гадаадад зорчих болон эх орондоо буцаж ирэх эрх нь хоорондоо нягт уялдаатай бөгөөд гадаадад зорчих эрх нь эх орондоо буцаж ирэх эрхийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх үндэслэл болно гэж тэмдэглэжээ. Тодруулбал, гадаадад зорчих эрх нь гадаад улсад аялах, тодорхой хугацаагаар оршин суух, цагаачлах зэрэг хүсэл сонирхлыг хангахад чиглэгддэг бол эх орондоо буцаж ирэх эрхийн хувьд хүний “өөрийн орон зай”, “гэртээ харих” гэсэн хүсэл сонирхол, өөриймсөг

¹ Magna Carta, Ch. 42. (<https://constitutioncenter.org/learn/educational-resources/historical-documents/magna-carta>)

² H. Summerson, 'The 1215 Magna Carta: Clause 42, Academic commentary', The Magna Carta Project (http://magnacarta.cmp.uea.ac.uk/read/magna_carta_1215/Clause_42?com=aca)

³ S.A.F. Jagerskiold, The freedom of Movement, in L. Henkin, (ed.) The International Bill of Rights, New York, Columbia University Press, 1981 p. 167-70.

хэрэгцээг ямагт илэрхийлдэг⁴. Өөрөөр хэлбэл, “*natural desire for a base or homeland*” буюу тухайн хүний өөрийн эх нутаг, эх орноо гэсэн байгалиас заяагдсан хүсэл сонирхол, урам зоригийг илэрхийлэх тул жам ёсны эрхийн шинжтэй байна⁵.

2.2 Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан байдал

Олон улсын эрх зүйд хүн бүр төрсөн цагаасаа эхлэн амьд явах эрхийн адил эх орондоо буцаж ирэх эрхийг эдлэх бөгөөд эх нутгаасаа ямар шалтгаанаар явснаас үл хамааран хэдийд ч эх нутагтаа буцах эрхтэй гэж үздэг⁶. Иймд эх орондоо буцаж ирэх эрх нь аливаа хүн өөрийн улс оронтой ямагт дотно, тусгай харилцаа холбоотой болохыг харуулж байдаг⁷.

2.2.1 Хүний эрхийн түгээмэл тунхаглал (*The Universal Declaration of Human Rights*)

1948 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын Ерөнхий Ассамблейгаас Хүний эрхийн түгээмэл тунхаглалын төсөл бэлтгэж, уг төслийг НҮБ-ын Хүний эрхийн комисс, тус комиссын дэргэдэх төсөл бэлтгэх хороо, Ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх болон цөөнхийн бүлгийн эрхийг хамгаалах дэд комисст хэлэлцүүлэх явцад “эх орондоо буцаж ирэх эрх”-ийн асуудал тусаагүй байсан бөгөөд Ерөнхий Ассамблейн 3 дугаар Хорооны хэлэлцүүлгийн үеэр Ливан Улсын төлөөлөгч анх санал гаргаснаар, энэ эрхийг нэмж тусгажээ.

⁴ D.D.N. Nseroko, The Right to Return Home, in «Indian Journal of International Law», vol. 21, 1981, p. 336: “It is innate in human nature to yearn to be back home”.

⁵ M. Cranston, The Political and Philosophical Aspects of the Right to Leave and to Return, in The Right to Leave and to Return: Papers and Recommendations of the International Colloquium Held in Uppsala, Sweden, 19-20 June 1972, New York, The American Jewish Committee, 1976, p. 28.

⁶ G.J. Boling, The 1948 Palestinian Refugees and the Individual Right of Return: An International Law Analysis, Bethlehem, BADIL Resource Center for Palestinian Residency and Refugee Rights, 2001, p. 5.

⁷ Олон улсын эрх зүйд “хүн болон тухайн хүний харьяаллын улс өөр хоорондоо дотно, урт удаан хугацааны тусгай харилцаа холбоотой байх” тухай ойлголт нь 1955 оны Олон улсын Эрүүгийн шүүхэд шийдвэрлэгдсэн “Nottebohm case”-ээс гаралтай гэж үздэг.

Түүнээс хойш “эх орондоо буцаж ирэх эрх”-ийг хүний эрхийн баримт бичгүүдэд зорчих эрхийн нэг хэлбэр болгон авч үзэх болсон. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13 дугаар зүйлд эх орондоо буцаж ирэх эрхийг дараах байдлаар баталгаажуулжээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13 дугаар зүйл

1. “Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.
2. Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй”.

Ямар ч хүн Тунхаглалын 13 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхдээ тунхаглалын 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан шаардлагыг биелүүлэх ёстой. Тунхаглалын 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй” гэж заажээ. Иймд тунхаглалын 13 дугаар зүйлд заасан эрхийг нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилгоор, гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд хязгаарлаж болно. Гэвч Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь заавал дагаж мөрдөх шинжийг агуулдаггүй тул олон улсын зан заншлын эрх зүйд тогтсон зарчмын хүрээнд харгалзан үзэж болно⁸.

2.2.2 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (*The International Covenant on Civil and Political Rights*)

1966 онд баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-д эх орондоо буцаж ирэх эрх, түүний агуулгыг олон улсын эрх зүйн үүднээс илүү тодорхой байдлаар тусгасан гэж үздэг⁹. Монгол

⁸ I. Brownlie, *Principles of Public International Law*, Oxford, Oxford University Press, 1990, p. 14-15.

⁹ H. Hannum, *The Right to Leave and Return in International Law and Practice*, Dordrecht, Martinus Nijhof, 1987, p. 24

Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр тус пактыг соёрхон баталсан бөгөөд 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

*Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын
12 дугаар зүйл*

1. “Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.
2. Хүн бүр аливаа улсыг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй.
3. Хуульд заасан бөгөөд үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад шаардлагатай хязгаарлалтаас бусдаар дээр дурдсан эрхийг хязгаарлаж болохгүй.
4. Хэний ч эх орондоо ирэх эрхийг дур мэдэн хасаж болохгүй”.

Пактын 12.3 дахь хэсэг нь “үндэсний аюулгүй байдал”, “нийтийн дэг журам”, “нийтийн ёс суртахуун”, “нийтийн эрүүл мэнд”, “бусдын эрх, эрх чөлөө”-г хамгаалах үүднээс “ардчилсан нийгэмд зохистой” хэмжээгээр, зөвхөн “хууль гаргаж” хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тухай нөхцөл юм. Гэвч судлаачид дээрх 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг буюу эрхийг хязгаарлах нөхцөлүүд (*limitation*) нь зөвхөн 12.1 болон 12.2 дахь хэсэгт хамаарна гэж тайлбарладаг¹⁰. Өөрөөр хэлбэл, 12.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр аль нэг нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх болон эх орноо орхин явах эрхийг хуулиар хязгаарлаж болно. Харин эх орондоо буцаж ирэх эрхийн хувьд тус пактын 12 дугаар зүйлд заасан бусад эрхүүдтэй харьцуулахад илүү туйлын (*absolute*) буюу жам ёсны шинжтэй тул 12.3 дахь хэсгийн хязгаарлалт хамаарахгүй¹¹.

¹⁰ “Г.Нарантуяа Гадаадад гацсан Монголчууд: Монгол Улсын Засгийн газар олон улсын эрх зүйн үүргээ зөрчсөн үү?” нийтлэл, 2020 оны 8 дугаар сарын 27, (<https://jargaldefacto.com/article/gadaadad-gatssan-mongolchuud-mongol-ulsiin-zasgiin-gazar-olon-ulsiin-erkh-zuin-uurgee-zurchsun-uu>)

¹¹ R. Aybay, The Right to Leave and the Right to Return: The International Aspect of Freedom of Movement, in “Comparative Law Yearbook”, vol. 1, 1977, p. 127.

Иймд эх орондоо буцаж эрхийг хязгаарлах үндэслэлийг пактын 12.4 дэх хэсгийн бичвэрт заасан нөхцөлийн хүрээнд тайлбарлах бөгөөд 12.4 дэх хэсэгт заасан нөхцөлөөс гадуур ямар нэг байдлаар хязгаарлахыг хүлээн зөвшөөрдөггүй. Энэ хэсэгт 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн агуулгыг дэлгэрэнгүй задлан авч үзье.

Олон улсын эрх зүйд тогтсон номлол, ойлголтоор 12.4 дэх хэсгийн бичвэрийг нэгдүгээрт “*arbitrarily*” буюу “дур зоргын” гэх нөхцөл, хоёрдугаарт “*his own country*” буюу “өөрийн эх орондоо” гэсэн үндсэн хоёр нөхцөлийн хүрээнд тайлбарладаг.

– *“arbitrarily” буюу “дур зоргын” гэсэн нөхцөлийн агуулгыг тайлбарлах нь*

Тус пактын зөвхөн 12.4 дэх хэсгийн бичвэрт “дур зоргын” гэх нөхцөлийг оруулсан явдал нь уг заалтыг ойлгож, тайлбарлахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэсэн гэж шүүмжлэгддэг. Гэвч тус хэсэгт “дур зоргын” гэх нөхцөл оруулаагүй бол эх орондоо буцаж ирэх эрх нь туйлын шинжтэй эрх болох үр дагавартай гэж зарим судлаач тэмдэглэсэн байна¹². Эндээс үзвэл, “дур зоргын” гэх нөхцөл нь эх орондоо буцаж ирэх эрх туйлын шинжтэй эрх биш болохыг харж болно. Иймд “дур зоргын” гэх нөхцөлийг хэрхэн тайлбарлахаас шалтгаалан эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлах үндэслэл тодорхой болно.

Судлаачдын тайлбараас үзвэл, “дур зоргын” гэх нөхцөл нь өргөн болон явцуу утгатай байна. Пактын төслийг боловсруулах шатанд зарим төлөөлөгч “дур зоргын” гэдгийг “хууль бусаар” гэх нөхцөлтэй ижил гэсэн томъёолол дэвшүүлж байсан ч энэ нь хэт явцуу утгатай гэсэн шүүмжлэлд өртсөн байдаг¹³.

Хүний эрхийн олон улсын гэрээний албан ёсны тайлбарыг тухайн гэрээний хэрэгжилтийг хянах, гэрээний дагуу гаргасан гомдлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий НҮБ-ын хороод гаргадаг¹⁴. Хүний эрхийн

¹² G.J. Boling, *The 1948 Palestinian Refugees and the Individual Right of Return: An International Law Analysis*, Bethlehem, BADIL Resource Center for Palestinian Residency and Refugee Rights, 2001, p. 38.

¹³ H. Hannum, *The Right to Leave and Return in International Law and Practice*, Dordrecht, Martinus Nijhof, 1987, p. 24

¹⁴ “Г.Нарантуяа Гадаадад гацсан Монголчууд: Монгол Улсын Засгийн газар олон

хороо 27 дугаар Ерөнхий зөвлөмждөө “дур зоргын” гэх нөхцөлийн талаар дараах зарчмын шинжтэй тайлбарыг хийжээ.

Хүний эрхийн хорооны тайлбар: “Энд дур зоргын тухай ойлголтыг дурдаж байгаа нь төрийн бүхий л үйл ажиллагаа, хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн хүрээнд хамаатай болохыг онцлох зорилготой; хуулийн дагуу хэрэгжих аливаа хөндлөнгийн оролцоо нь энэ пактын зүйл, заалт, зорилгод нийцсэн байх ёстой бөгөөд ямар ч онцгой нөхцөлд тодорхой үндэслэлтэй байх ёстой. Хорооноос эх орондоо эргэн ирэх эрхийг хязгаарлах тохиолдол байж болдог юм гэхэд ийм нөхцөл нэн ховор тохиолдолд гэж үзнэ. Төрөөс хүний иргэншлийг хасах эсхүл хувь хүнийг гуравдагч улс руу хөөх замаар хүнийг эх орондоо буцаж ирэх явдалд дур мэдэн саад учруулах ёсгүй”¹⁵ гэж тэмдэглэжээ.

Мөн олон улсын гэрээний үүргээс ухрах (*derogation*) замаар хүний зарим эрхэд хязгаарлалт хийж болохыг пактын 4.1 дэх хэсгээр зохицуулжээ. Пактын 4.1 дэх хэсэгт “Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс уг Пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь олон улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна зөвхөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчлах явдалд хүргэхгүй байх ёстой” гэж заасан байна.

Дээрх тайлбараас үзвэл, эх орондоо буцаж ирэх эрхийг Пактын 4.1-д заасан нөхцөл буюу “улс үндэстний амьдралд аюул занал тулгарч”, энэ тухай “албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон” үед хурцадмал шинжид дүйх хэмжээгээр хязгаарлаж болохоор байна. Энэхүү хязгаарлалт нь гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд байх бөгөөд хүний арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчлах явдалд хүргэхгүй байх ёстой.

улсын эрх зүйн үүргээ зөрчсөн үү?” нийтлэл, 2020 оны 8 дугаар сарын 27, (<https://jargaldefacto.com/article/gadaadad-gatssan-mongolchuud-mongol-ulsiin-zasgiin-gazar-olon-ulsiin-erkh-zuin-uurgee-zurchsun-uu>)

¹⁵ General Comment 27, CCPR/C/21/Rev.1/Add.9 of 2 November 1999.

– *“his own country” буюу “өөрийн эх орондоо” гэсэн нөхцөлийн утгыг тайлбарлах нь*

Эх орондоо буцаж ирэх эрхийг эдлэх субъект нь мэдээж аль нэг улсын харьяалалд байгаа хүн байхаас гадна тухайн улсад төрөөгүй хүн төдийгүй тус улсад хэзээ ч оршин сууж байгаагүй бүхий л үндэстэн хамаарна гэж үздэг¹⁶. Энэ нь Пактын 2.1 дэх хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй” гэж заасантай холбоотой.

Хүний эрхийн хороо *“his own country”* буюу “өөрийн эх орондоо” гэх нөхцөлийн талаар тайлбарлахдаа “Өөрийн эх орондоо” гэх нөхцөл нь тухайн хүний өөрийнх нь “харьяаллын улс” гэсэн ойлголтоос илүү өргөн хүрээтэй. Өөрөөр хэлбэл, энэ нь хүн төрөхдөө эсхүл харьяат болох хүсэлт гаргах замаар олж авсан албан ёсны харьяаллаар хязгаарлагдахгүй. Хүнийг өөрийнх нь улс оронтой холбоотой ямар нэг онцгой шалтгаанаар тухайн хүнийг харийн хүн гэж үзэж болохгүй. Харин олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчиж өөрийн харьяаллаа алдсан улсын иргэд болон аль нэг өөр улсын харьяалалд нэгдсэн эсхүл шилжсэн бол тухайн иргэдийн хувьд өмнөх улсын харьяалал нь үгүйсгэгдэнэ”¹⁷ гэжээ.

Хүний эрхийн хорооны тайлбараас дүгнэвэл, эх орондоо буцаж ирэх эрхийг зарчмын хувьд хязгаарлаж үл болох бөгөөд “улс үндэстний амьдралд аюул занал тулгарч”, энэ тухай “албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон” тохиолдолд олон улсын гэрээний үүргээс ухрах замаар хязгаарлаж болно. Мөн нэн ховор онцгой нөхцөл байдлын үед хязгаарлах тохиолдолд энэ нь тодорхой үндэслэлтэй байх ёстой.

¹⁶ Н. Hannum, *The Right to Leave and Return in International Law and Practice*, Dordrecht, Martinus Nijhof, 1987, p. 56

¹⁷ General Comment 27, Paragraph 20, CCPR/C/21/Rev.1/Add.9 of 2 November 1999

Манай улсын хувьд коронавируст халдварын цар тахлын үед “онц байдал” зарлаагүй тул эх орондоо буцаж ирэх эрхийн хязгаарлалтыг Пактын 4.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр тайлбарлах боломжгүй. Харин Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (цаашид Ковид-19 хууль гэх)-д хүний эрхийг хязгаарлахад тавигдах шаардлага, үндэслэлийг нэг бүрчлэн тусгасан байна. Иймд коронавируст халдварын цар тахлын үед төрөөс гаргасан шийдвэр, арга хэмжээ нь Ковид-19 хуульд заасан шаардлагыг нэг мөр хангаж байгаа эсэхээс хамааран тус Пактын 12.4 дэх хэсэгт заасан “дур зоргын” шинжийг тайлбарлаж болох юм.

2.2.3 Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (*International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination*)

Монгол Улс 1969 оны 3 дугаар сарын 31-ний өдөр “Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц”-ийг соёрхон баталж, мөн оны 9 дүгээр сарын 5-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцын 5 дугаар зүйл

“Оролцогч улсууд энэхүү Конвенцын 2 дугаар зүйлд заасан үндсэн үүргийн дагуу арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг хориглон устгах хийгээд арьс үндэс, арьсны өнгө, үндэсний буюу угсаатны гарал үүслийг үл харгалзан, хүн бүрийн дараах эрхийг эдлэхэд нь хуулийн өмнө тэгш байхыг хангана”.

5(d)(ii) дахь хэсэгт “аливаа улс, түүний дотор эх орноо орхин явах, эх орондоо эргэж ирэх эрх”.

Дээрх конвенцоор оролцогч улс бүр хүн, бүлэг хүмүүс буюу байгууллагын эсрэг арьс үндсээр алагчлах үйлдэл, үйл ажиллагаа явуулахгүй байх үүрэг хүлээж, улсын болон орон нутгийн төрийн бүх байгууллага, албан газрыг конвенцод заасан үүргийн дагуу ажиллуулах, арьс үндсээр алагчлах үзлийг ивээн тэтгэх, хамгаалах, дэмжихгүй байх, арьс үндсээр алагчлах үзлийг бий болгох, эсхүл тогтоон хадгалахад чиглэсэн аливаа хууль тогтоомжийг өөрчлөх буюу хүчингүй болгохын тулд үр дүнтэй арга хэмжээ авах үүрэгтэй.

Энэ хүрээнд аливаа хүн эх орноо орхин явах, эх орондоо эргэж ирэх эрхээ эдлэхэд нь арьс үндэс, арьсны өнгө, үндэсний буюу угсаатны гарал үүслийг үл харгалзан, хуулийн өмнө тэгш байх боломжоор хангах ёстой. Хэрэв энэ эрхээ хэрэгжүүлэхэд нь арьс үндэс, арьсны өнгө, үндэсний буюу угсаатны гарал үүслээр шалтгаалж зүй бусаар саад учруулсан бол арьс үндсээр алагчилсан гэж үзнэ.

2.2.4 Хүүхдийн эрхийн тухай конвенц (*Convention on the Rights of the Child*)

Монгол Улс 1990 оны 7 дугаар сарын 5-ны өдөр “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийг соёрхон баталж, мөн оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг

“Эцэг эх нь өөр улсад амьдарч байгаа хүүхэд онцгой шалтгаангүй тохиолдолд эцэг эхтэйгээ тогтмол хувийн болон шууд харилцаатай байх эрхтэй. Энэ зорилгоор, мөн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор, оролцогч улсууд хүлээсэн үүргийнхээ дагуу эх орноосоо буюу өөр аливаа улсаас гарах, эх орондоо эргэж ирэх хүүхдийн болон түүний эцэг, эхийн эрхийг хүндэтгэнэ. Аливаа орныг орхин гарах эрхийн хувьд гагцхүү үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, нийтийн эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс хуулиар тогтоосон болон энэхүү Конвенцоор хүлээн зөвшөөрсөн бусад эрхтэй нийцсэн хязгаарлалт хийнэ”.

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахыг эн тэргүүний зорилго болгож, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг ямагт хангаж ажиллахыг оролцогч бүх улсад үүрэг болгосон. Монгол Улс тус конвенцыг соёрхон баталж, дагаж мөрдөж байгаагийн хувьд Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай конвенцын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт хүлээсэн үүргийнхээ дагуу коронавируст халдварын цар тахлын үед эх орондоо буцах хүсэлт гаргасан өөрийн улсын харьяат хүүхэд болон тэдний эцэг, эхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эн тэргүүнд зөрчигдөхөөс хамгаалж, түүнд чиглэсэн арга хэмжээ авах учиртай.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ, ХЯЗГААРЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Монгол Улсын Үндсэн хууль ба бусад хууль, тогтоомжид заасан шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд “Эх орондоо буцаж ирэх эрх”-ийн талаар дараах байдлаар тодорхой заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.18 дахь хэсэгт “... гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно” гэж заажээ.

Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан нарын бүтээсэн Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбарт, дээрх 16.18 дахь хэсэгт баталгаажуулсан “Эх орондоо буцаж ирэх эрх”-ийг гадаадад түр буюу байнга оршин сууж байсан буюу гадаадад зорчсон, цагаачилсан Монгол Улсын иргэд ямар шалтгаан, зорилгоор анх гадаадад гарснаас нь үл шалтгаалан хүссэн цагтаа эх орондоо буцаж ирэх эрхтэй бөгөөд энэ эрхийг эдлэхэд төр засгийн ямар нэг хэлбэрийн саад хязгаарлалт тогтоож болохгүй¹⁸ гэж тайлбарлажээ.

Монгол Улсын иргэдийн гадаадад явах, цагаачлах, эх орондоо буцаж ирэх эрхийг хэрэгжүүлэх асуудлыг 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиар зохицуулдаг¹⁹. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн хувийн хэргээр гадаадад зорчих, цагаачлах эрхтэй”, 4.2 дахь хэсэгт “Гадаадад цагаачилсан Монгол Улсын иргэн хэдийд ч эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэж тус тус заажээ. Энэ хуульд зааснаар төрийн болон засаг захиргааны нэгж, хот, тосгоны

¹⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000 он, хууд. 125-126, Г.Совд Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (харьцуулсан эрх зүй)” УБ., 1999 он, хууд. 102-103.

¹⁹ Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах, эх орондоо буцаж ирэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

өөрөө удирдах байгууллага, Улсын Их Хуралд суудал бүхий нам, төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын шийдвэр, түүнчлэн гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэж байгаа байгууллагын ажлаар явахаас бусдыг гадаадад хувийн хэргээр зорчих гэнэ. Харин гадаадад хувийн хэргээр байнга амьдран суухаар Монгол Улсаас гарч явахыг цагаачлах гэнэ.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг дор дурдсан тодорхой үндэслэлээр хязгаарлахыг хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд:

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль

5 дугаар зүйл. Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх

1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг дараах үндэслэлээр дор дурдсан хугацаагаар түдгэлзүүлнэ:

1. гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэх хүртэл;
2. эрүүгийн ял шийтгүүлсэн бол уг ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл;
3. хуулиар тогтоосон төрийн нууцыг мэдэж байгаа болон түүнийг шууд хариуцаж байгаа албан тушаалтан цагаачлах хүсэлт гаргасан бол уг ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн өдрөөс хойш 3 жилийн дотор;
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол шийдвэрт заасан хугацаагаар;

5. хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан, эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн этгээдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаагаар.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэлээр Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг хязгаарлахыг хориглоно.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлд Монгол Улсын иргэний гадаадад явах, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, хязгаарлах дөрвөн үндэслэлийг заасан хэдий ч эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлах үндэслэлийг тусгайлан заагаагүй байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.18 дахь хэсэгтэй холбоотой байж болох юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.18 дахь хэсгийн бичвэрт үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор зөвхөн гадаадад явах, оршин суух эрхийг хуулиар хязгаарлахыг хүлээн зөвшөөрсөн байх хэдий ч энэ хязгаарлалтад эх орондоо буцаж ирэх эрх хамаарахгүй байна.

Тиймээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад зааснаар эх орондоо буцаж ирэх эрхийг зөвхөн “онц болон дайны байдал” зарласан тохиолдолд гагцхүү хуулиар хязгаарлах зохицуулалттай Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг²⁰ нийцсэн гэж үзэж болох юм.

3.2 Ковид-19 хууль ба бусад хууль тогтоомжийн шаардлага

НҮБ-ын Хүний эрхийн хороо, Хүний эрхийн дээд комиссарын газраас коронавируст халдварын цар тахлыг “улс үндэстний амьдралд аюул занал тулгарсан” нөхцөл байдал гэж үзэж болохоо илэрхийлж, хүний

²⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заасан.

эрхийг хуулиар хязгаарлах тохиолдолд тодорхой шалгууруудыг хангах ёстой болохыг дурдсан байна²¹.

2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас баталсан Ковид-19 хуульд цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд хуулийн шаардлагыг нэг мөр хангахыг үүрэг болгосон. Ийнхүү иргэдийн зарим үндсэн эрхэд хязгаарлалт хийхтэй холбоотой тодорхой шалгууруудыг заавал хангасан байхыг уг хуулийн 11 дүгээр зүйлд дараах байдлаар тусгажээ. Үүнд:

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

11.1. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг нэг мөр хангана:

- 11.1.1. хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх;
- 11.1.2. үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх;
- 11.1.3. энэ хуулийн 11.1.2-т заасан зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх;
- 11.1.4. хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх;

²¹ United Nations Human Rights, Office of the High Commissioner “Emergency measures and Covid-19: Guidance” 2020.04.27 (https://www.ohchr.org/Documents/Events/EmergencyMeasures_COVID19.pdf)

11.1.5. хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх.

11.2. Энэ хуульд заасан арга хэмжээ нь тухайн нөхцөлд тохирсон тодорхой хамрах хүрээ, хугацаатай байх бөгөөд цугларсан мэдээллийг нийгмийн эрүүл мэндийг хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахыг хориглоно.

11.3. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан, бодитой, тохирсон байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг хязгаарлахад заавал хангах ёстой дараах нөхцөлийг тусгасан гэж судлаач О.Мөнхсайхан тэмдэглэснийг дурдах нь зүйтэй. Үүнд: а) хуульд тодорхой заасан байх, б) үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн байх, в) зайлшгүй буюу тохирсон байх, г) үндсэн эрхийг аль болох эдлүүлэх, д) ялгаварлан гадуурхахгүй байх, е) хараат бус шүүхээр хянагддаг байх гэсэн зургаан нөхцөл хамаарна²². Ковид-19 хуулийн 11 дүгээр зүйлд эдгээр нөхцөлийг тодорхой тусгасан байх бөгөөд хуульд заасан нөхцөлийг бүгдийг нь хангахгүйгээр хүний эрхийг хязгаарлахыг хатуу хориглосон²³.

Иймд Монгол Улсын Засгийн газраас иргэдийн эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарласан шийдвэр нь Ковид-19 хуульд заасан шаардлагыг нэг мөр хангаж байгаа эсэхийг шалгая.

²² О.Мөнхсайхан “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт” Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, 2017 он

²³ “О.Мөнхсайхан: Хүний эрхийг хязгаарлах бол тодорхой шалгуурыг хангах ёстой” ярилцлага, Өнөөдөр сонин, 2020 оны 5 дугаар сарын 18

3.2.1 Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх

Хүний төрөлх болон салшгүй эрхээс бусад үндсэн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг болох хууль дээдлэх ёсны үзэл санаанд тулгуурлана.

Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заасан. Энэхүү 19.2 дахь заалт нь онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хуулиар хязгаарлаж үл болох бөгөөд хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглоно гэсэн агуулгатай. Өөрөөр хэлбэл, 19.2-т заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана.

2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Гамшгаас хамгаалах тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.7 дахь хэсэгт өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед “харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах” хүртэлх арга хэмжээг авч болно гэж заажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 102 дугаар тогтоол нь Монгол Улсын Хилийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 28.2 дахь хэсгүүдэд тус тус үндэслэсэн байна. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Хүн, мал, амьтан, ургамлын халдварт өвчин Монгол Улсын болон хил залгаа улсын нутагт тархах аюулыг хязгаарлах зорилгоор өвчин гарсан голомтын хэсэгт улсын хил дээр зорчигч, тээврийн хэрэгслийн

хөдөлгөөнийг түр зогсоох, хязгаарлах, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ”, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт “Хилийн боомтыг түр хаах, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ” гэж тус тус заасан.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас коронавируст халдварын цар тахлын үед улсын нутагт тархах аюулыг хязгаарлах зорилгоор хилийн бүх боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг зогсоосон шийдвэр нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гарчээ.

3.2.2 Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж заасан. Иймд коронавируст халдварын цар тахлын үед үндэсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор иргэдийн зарим үндсэн эрхэд тодорхой хязгаарлалт хийх нь зүй ёсны гэж үзнэ. Тухайлбал, зорчих эрхийн хувьд улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух эрх гэх мэт. Харин эх орондоо буцаж ирэх эрхийг “онц болон дайны” байдал зарласнаас бусад тохиолдолд хязгаарлаж үл болох жам ёсны шинжтэй онцгой эрх гэж олон улсын эрх зүйд үздэг. Иймд цар тахал буюу онцгой нөхцөл байдлын үед төрөөс улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор иргэдийнхээ улсын хилээр зорчих хөдөлгөөнийг зогсоож, эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлах бол энэ нь хамгийн багаар хязгаарласан байх, тухайн нөхцөлд тохирсон байх зэрэг шаардлагуудыг хангасан байх ёстой.

3.2.3 Дээрх зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх

Бодит нөхцөлд тохирно, зорилгодоо нийцнэ гэдэг нь цугларсан бүх мэдээлэлд дүн шинжилгээ хийгээд түүнд тохирсон, хэтрүүлээгүй, дутуу үнэлээгүй хариу арга хэмжээ авахыг хэлнэ²⁴.

Дэлхийн ихэнх улс оронд цар тахлын халдварын тархалтын хамрах хүрээ өргөн, эрсдэл өндөр зэрэглэлтэй үед зөвхөн Монгол Улсын хилийн дотор нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор иргэдийнхээ эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлах нь Монгол Улсын нийт хүн амын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон арга хэмжээ гэж үзэх боломжгүй юм. Учир нь гадаадад байгаа иргэдийн эх орондоо буцаж ирэх үндсэн эрхийг хязгаарласнаар тухайн иргэдийн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох зэрэг бусад үндсэн эрх шууд бус байдлаар зөрчигдөх эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл, хүний эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарласны үр дүнд бусад салшгүй эрх зөрчигдөх үр дагавар үүсэж болно. Энэ талаар Ковид-19 хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь хэсэгт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр нь “хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх” шаардлагыг хангах ёстой гэж заасан. Гэвч улсын хилээр зорчих хөдөлгөөнийг хязгаарласны улмаас хилийн чанадад байсан зарим иргэдийн амьд явах эрх зөрчигдөж, тусгай үүргийн нислэг хүлээх хугацаанд коронавирусын халдвар, өвчин, сэтгэл санааны байдлаас болоод амь нас эрсдэх тохиолдлууд гарч байсан²⁵. Иймд иргэдийн эх

²⁴ “Хуульч Д.Сүнжид: Төр гадаадаас авчирч буй иргэдээ бүх зардлаа өөрсдөө хариуц гэх нь оновчгүй” ярилцлага, Ulaanbaatar news, 2020 оны 5 дугаар сарын 27 (<https://ubn.mn/p/3655>)

²⁵ Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас хилийн чанадад нас барсан зарим иргэний шарилыг чандарлах, эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсгийн санхүүжүүлсэн. Тухайлбал, “Т.Нямцэрэн: Тусгай үүргийн онгоц хүлээж байгаад нас барсан аавын минь чандрыг дүү минь Монгол руу авч явна” ярилцлага,

орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлах шийдвэр нь үндэсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх шаардлагыг хангаагүй гэж үзнэ.

3.2.4 Энэ хуульд заасан арга хэмжээ нь тухайн нөхцөлд тохирсон тодорхой хамрах хүрээ, хугацаатай байх

Ковид-19 хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.19 дэх заалтад Монгол Улсын Засгийн газар “улсын хилээр нэвтрэх болон дотоодын зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тодорхой хугацаанд хязгаарлалт хийх” гэж заасан. Улсын хилээр нэвтрэх хөдөлгөөний хязгаарлалт тодорхой хугацаатай байх шаардлага нь гадаадад байгаа иргэдийн эх орондоо буцаж ирэх эрхийг хамгийн багаар хязгаарласан байх шаардлагатай холбоотой.

Монгол Улсын хэмжээнд нийт 19 боомт ажилладаг. Үүнээс агаарын замын нэг (Буянт-Ухаа), БНХАУ-тай хиллэдэг хэсэгт нийт найм буюу авто замын долоо (Булган-Такашикэн, Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсүхайд-Ганц мод, Ханги-Мандал, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүн хатавч, Баянхошуу-Өвдөг), төмөр замын нэг (Замын-Үүд-Эрээн), ОХУ-тай хиллэдэг хэсэгт нийт арав буюу авто замын найм (Цагааннуур-Ташанта, Тэс-Шарсуурь, Боршоо-Хандгайт, Арцсуурь-Цагаантолгой, Ханх-Монд, Алтанбулаг-Хиагт, Ульхан-Дээд Ульхан, Эрээнцав-Соловьевск), төмөр замын хоёр боомт (Сүхбаатар-Наушка, Эрээнцав-Соловьевск) тус тус ажиллаж байна²⁶.

Монгол Улсын хувьд Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн “Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” 39 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн дагуу Монгол Улс, БНХАУ-ын хилийн агаарын зам, төмөр зам, авто

2020 оны 9 дүгээр сарын 8 (<http://isee.mn/n/13179?fbclid=IwAR0fCyCEUQ3bx9XtRM1IDy-XrCvMy7P-0haU8Qb3uxNYnk6c-hyGNDM5MtQ>), “Т.Эрдэнэзул: Найман хүн гадаадад гацах хугацаандаа нас барсан, энэ тоо өсөхөөс айж байна” ярилцлага, 2020 оны 8 дугаар сарын 3 (<http://itoim.mn/article/l6tLE/22901>)

²⁶ Covid-19 халдварын тархалттай холбоотойгоор ОХУ, БНХАУ-аас хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд авч хэрэгжүүлж буй онцлог арга хэмжээ, хилийн боомтуудын үйл ажиллагааны талаарх Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын аюулгүй байдлын хэлтсийн ахлах офицер Н.Наранцогтын ярилцлага (<https://newswall.mn/?p=27031>)

замын бүх боомтоор БНХАУ-ын иргэд болон тус улсаас ирж байгаа гуравдагч орны иргэн, харьяалалгүй хүнийг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Монгол Улс руу нэвтрүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн. Ийнхүү Монгол Улс болон БНХАУ-ын хилээр нэвтрэх зорчигч тээврийн бүх хөдөлгөөн зогссон.

Харин 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” Дугаар 102 тогтоолын 3 дахь хэсгийн дагуу Оросын Холбооны Улсаас зорчин ирэх Монгол Улсын иргэдийг 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 20:00 цагаас 3 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд зөвхөн Алтанбулаг боомтоор улсын хилээр нэвтрүүлсний үндсэн дээр хилийн бүх боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд зогсоосон. Харин 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс хойш тус хугацааг 9 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл²⁷, 9 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацааг 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл²⁸, 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг 12 дугаар сарын сарын 31-ний өдрийг хүртэл²⁹ тус тус сунгасан байна.

Дээрх байдлаар улсын хилээр зорчих хөдөлгөөнийг хязгаарласан хугацааг удаа дараа сунгаж, тодорхойгүй хугацаагаар хязгаарласнаас үүдэн гадаадад байгаа иргэдийн эх орондоо буцаж ирэх эрх зөрчигдсөөр байна. Тухайлбал, 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор 11 дүгээр сард төлөвлөгдсөн байсан тусгай үүргийн бүх нислэгийг цуцалсан. Үүний улмаас эх орондоо ирэхээр төлөвлөж байсан нийт 1980 иргэнээс 1480 иргэн эх орондоо ирэх боломжгүй болж³⁰, санхүү болон сэтгэл санаа, эрүүл мэндээрээ хохирч, хүнд нөхцөл байдалд ороод байна³¹. Иймд улсын

²⁷ 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 70 дугаар тогтоол.

²⁸ 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Засгийн газрын 103 дугаар тогтоол.

²⁹ 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын 159 дүгээр тогтоол.

³⁰ Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудас, (<https://nema.gov.mn/n/108037>)

³¹ “Шведэд Монгол руу буцах хүсэлтэй 50 хүн маш хүнд нөхцөлд байна: (<https://news.mn/r/2375558/>), “Франкфурт-Улаанбаатар чиглэлийн тусгай үүргийн нислэг цуцлагдсанаас иргэд амьдрах газаргүй “болоод байна (<http://mongol.tv.mn/post/56865>)

хилээр зорчих хөдөлгөөнийг хязгаарласан шийдвэр нь тодорхой хугацаатай байх шаардлагыг хангаагүй.

3.2.5 Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх

Гадаадад байгаа иргэд Монгол Улсын иргэн мөн болохынхоо хувьд гадаадад ямар зорилгоор явснаас үл шалтгаалан бусад иргэний адил Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ. Хэдийгээр 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл гадаадад байгаа иргэдийг татан авч ирэх ажлыг тодорхой үе шаттай хэрэгжүүлж байсан энэ хугацаанд эх орондоо буцах хүсэлт гаргасан иргэн бүр татан авах ажиллагаанд хамрагдаж чадаагүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу төрөөс гаргах аливаа шийдвэр, арга хэмжээ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй байх ёстой. Иймд хүн амын аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Монгол Улсын иргэнийг хилийн дотор эсхүл гадна гэж ялгамжтай авч үзэж, эх оронд нь авч ирэх ажлыг зогсоогоод байгаа нь ялгаварлан гадуурхахгүй байх шаардлагыг хангаагүй байна. Төр өөрөө ялгаварлан гадуурхаж болохгүйн зэрэгцээ бусад хувь хүн, хуулийн этгээдээс үзүүлж буй ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох үүрэгтэй. Энэ үүргээ үл биелүүлбэл ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зөрчигдөнө³².

³² О.Мөнхсайхан “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт” Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, 2017 он, 96 дахь тал

3.2.6 Цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан, бодитой, тохирсон байх

НҮБ-ын Хүний эрхийн хороо, Хүний эрхийн дээд комиссарын газраас коронавируст цар тахлын үед төрөөс хүний эрхийн гэрээний үүргээс ухарч, хүний эрхийг хязгаарлах шийдвэр гаргахдаа урьдчилан тогтоосон хугацаанд, хүний эрх, эрх чөлөөнд хамгийн бага хязгаарлалт тогтоосон байх ёстой гэж сануулсан³³. Энэ нь хүний эрхийг хязгаарлахдаа “үндсэн эрхийг аль болох эдлүүлэх” гэсэн шаардлагын агуулгыг илэрхийлдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “эрх чөлөө” бол төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж заасан. Эрх чөлөөний зарчим нь үндсэн эрхийг аль болох эдлүүлэх, үндсэн эрхийг зайлшгүй тохиолдолд хязгаарлаж болох ч тэрхүү хязгаарлалт нь тухайн эрхийн агуулгыг бүрэн үгүйсгэхгүй байх, хуулийн талаарх тайлбаруудаас үндсэн эрхэд илүү нийцсэнийг нь хэрэглэх зэрэг олон утгыг багтаадаг³⁴.

Коронавируст цар тахлын үед төрөөс гаргах шийдвэр, арга хэмжээ нь зөвхөн улсын дотоодод байгаа иргэд төдийгүй, гадаадад байгаа иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зорилгод чиглэх ёстой. Иймд иргэдийнхээ хилээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарласан тохиолдолд тухайн иргэдийг татан авах ажиллагааг нэн даруй явуулж, эх орондоо буцаж ирсэн иргэдэд коронавирусын халдвар, тохиолдол илэрсэн бол төр иргэнийхээ өмнө хүлээсэн үүргийн дагуу тухайн халдвар, тохиолдлыг тусгаарлах, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх учиртай. Үүнтэй холбоотойгоор төрөөс тусгаарлах байрны тоо, хүрэлцээ, эмч, эмнэлгийн ажилтнууд, бусад төрийн албан хаагчдын хүний нөөц зэрэг дотоодын хүлээн авах чадварыг эн тэргүүнд яаралтай нэмэгдүүлж, аюулгүй байдал, зохион байгуулалтын үйл ажиллагааг чанд мөрдөж, хяналт тавьж ажиллах ёстой. Гэвч иргэдийнхээ хилээр нэвтрэх эрхийг

³³ United Nations Human Rights, Office of the High Commissioner “Emergency measures and Covid-19: Guidance” 2020.04.27 (https://www.ohchr.org/Documents/Events/EmergencyMeasures_COVID19.pdf)

³⁴ О.Мөнхсайхан “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт” Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, 2017 он, 95-96 дахь тал

тодорхойгүй хугацаанд хязгаарлаж, 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш татан авах ажиллагааг гэнэт зогсоосон нь тухайн иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, эдийн засагт маш өндөр эрсдэл үүсгэх тул *тухайн нөхцөлд тохирсон байх* шаардлагыг хангаагүй байна.

Дээрх нөхцөл байдлаас үзвэл, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын иргэдийн улсын хилээр нэвтрэх хөдөлгөөнийг хориглож, эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарласан шийдвэр нь Ковид-19 хуулийн 11 дүгээр зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, шаардлагыг нэг мөр хангаагүй байна. Иймд тухайн шийдвэр нь олон улсын эрх зүйн нэр томъёоны дагуу “дур зоргын” шинжтэй байх тул Монгол Улсын иргэдийн эх орондоо буцаж ирэх эрхийг “дур зоргоор” хязгаарласан гэж үзнэ.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД УЛСАД БАЙГАА ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН БОДЛОГО БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

4.1 Монгол Улсын Засгийн газар, УОК-ын шийдвэр, арга хэмжээ

Анх Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит бус хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу БНХАУ-д тархсан шинэ коронавирусын голомт болох Ухань хотод хөл хорионд орсон 32 оюутныг эх оронд нь шилжүүлэн авах тухай албан ёсны хүсэлтийг Гадаад харилцааны яам Бээжин дэх Элчин сайдын яамаараа дамжуулан тавьж, 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдөр тусгай үүргийн нислэгээр татан авах ажиллагааг эхлүүлсэн. 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу нийт 118 удаагийн тусгай үүргийн төлөвлөгөөт нислэг үйлджээ.

Гэсэн хэдий ч 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр дотооддоо халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” Дугаар 181 тогтоолоор коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл сунгасан байна³⁵. Энэ үйл явдалтай холбоотойгоор 2020 оны 11 дүгээр сард нийт 1,980 иргэнийг татан авахаар 10 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэхээр төлөвлөснөөс 7 нислэгийг цуцалж, тодорхойгүй хугацаагаар хойшлуулжээ³⁶.

³⁵ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” Дугаар 194 тогтоолоор 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цагийг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаагаар сунгасан.

³⁶ Гадаад харилцааны яамны Консулын газрын дарга Л.Мөнхтүшиг, <https://gogo.mn/r/v4ddd>

УОК-оос иргэдийг тээвэрлэх ажиллагааг зохион байгуулж эхэлсэн үеэс эх орондоо буцах хүсэлт гаргасан иргэдэд нэн хүндэтгэн үзэх шалтгаантай байхыг шаардаж, үүнд а) эрүүл мэндийн шалтгаантай (хүнд өвчний улмаас эмнэлгийн магадалгаагаар гадаад улсад эмчилгээнд явсан), б) жирэмсэн, в) бага насны (14 хүртэлх настай) хүүхэдтэй гэр бүл, г) хөгжлийн бэрхшээлтэй, д) өндөр настан (60-аас дээш настай) гэсэн таван шалгуурыг оруулсан. Эдгээр таван шалгуурын аль нэгийг хангахгүй иргэдийн хувьд “шаардлага хангаагүй” гэх үндэслэлээр тусгай үүргийн нислэгт багтаж чадаагүй³⁷.


Гадаад улсаас тусгай үүргийн нислэгээр ирсэн нийт иргэний тоо, шалтгааныг 2020 оны 5, 8 дугаар сар болон 2021 оны 1 дүгээр сарын үеийн нөхцөл байдлаар нь дэлгэрэнгүй задалж үзвэл, 2020 оны 5 дугаар сарын 19-ний байдлаар дэлхийн 46 улсаас 10,761 иргэн эх орондоо ирэх хүсэлт гаргасан байдаг. Эдгээр иргэнээс бага насны хүүхэдтэй 1,611; эрүүл мэндийн шалтгаантай 449; өндөр настан 869; богино хугацааны визтэй 158; 2,818 оюутан; санхүүгийн боломжгүй 1,002; насанд хүрээгүй 358 хүүхэд; бусад гэсэн шалтгаантай нийт 3,300 хүн байна³⁸. Харин 8 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар тусгай үүргийн нислэгээр тээвэрлэсэн нийт 13,951 иргэн тус бүрийн шалгуурыг дараах байдлаар тодорхойлжээ (график 1-ийг харна уу).

³⁷ Жишээлбэл, 2020 оны 7 дугаар сарын байдлаар дэлхийн 55 орноос эх орондоо буцах хүсэлт гаргасан нийт 11,951 иргэний 5,497 нь УОК-оос тавьж буй таван шалгуурт нийцээгүй гэсэн байна. (<https://ikon.mn/n/1y0u>)

³⁸ “Б.Ууганбаяр: Энэтхэг рүү дахин тусгай нислэг үйлдэхээр бэлтгэж байна”, <https://montsame.mn/mn/read/225945>, <https://medee.mn/p/148647>

График 1.

2020 оны 8 дугаар сарын 27-ны байдлаар тусгай үүргийн онгоцоор ирсэн иргэдийн хүндэтгэн үзэх шалтгаан (хувиар)



(Эх сурвалж: Гадаад харилцааны яам)

2020 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн тоо баримтаас үзвэл хүсэлт гаргасан нийт 3,300 иргэнээс 1,960 иргэн буюу ойролцоогоор 60 хувийг бага насны хүүхэдтэй гэр бүл, насанд хүрээгүй хүүхэд, 1,002 иргэн буюу 33 хувийг санхүүгийн боломжгүй иргэд эзэлжээ.

Түүнээс хойш 3 сарын дараа буюу 8 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар График 1-д дурдсан тоо баримтаас үзэхэд, гадаад улсаас эх орондоо ирсэн иргэдийн 57 хувь буюу хамгийн их хувийг санхүүгийн бэрхшээлтэй, ар гэрийн гачигдалтай, орон байргүй болсон, визний асуудалтай зэрэг шалтгаан, түүний дараа 17 хувийг бага насны хүүхэдтэй гэр бүл тус тус эзэлсэн байна.


2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар гадаадын 93 гаруй орноос агаарын замаар 21,522; автозамаар 6,643 буюу нийт 28,195 иргэнийг татан авчээ³⁹. Агаарын замаар ирсэн нийт 19,939 иргэнийг шалтгаан тус бүрээр нь задалж График 2-т үзүүлэв⁴⁰.

³⁹ Эрүүл мэндийн яамны Ковид-19 халдварын цаг үеийн нөхцөл байдлын тухай ээлжит мэдээлэл (2020.10.30) (<http://www.shuud.mn/a/523842>), <https://www.ugluu.mn/436500.html>, <http://eagle.mn/r/78436>

⁴⁰ 2020.11.11-ний өдрийн Токио-Улаанбаатар чиглэлийн нислэгээр ирсэн 146 иргэн,

График 2.

2021 оны 1 дүгээр сарын 18-ны байдлаар тусгай үүргийн онгоцоор ирсэн иргэдийн хүндэтгэн үзэх шалтгаан (хувиар)



Дээр дурдсан нийт тоо баримтаас үзвэл, гадаадаас эх орондоо ирж байгаа нийт иргэдийн 57-58 орчим хувийг санхүүгийн хүндрэл, бэрхшээл болон бусад шалтгаантай иргэд, 17-18 орчим хувийг бага насны хүүхэдтэй иргэд эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх 5, 8 дугаар сарын нөхцөл байдлаас ялгаагүй байна. Эндээс дүгнэвэл, төрөөс тусгай үүргийн төлөвлөгөөт нислэгийг сар бүр хөөргөж байгаа ч гадаадад байгаа дийлэнх иргэдэд санхүүгийн хүндрэл, бэрхшээл бодитоор тулгарсаар байгааг харж болно. “Public Mongolia” ТББ-ын 98 хүнийг хамруулсан анкет судалгаагаар нийт судалгаанд оролцогчдын 5.1 хувь нь нь гадаадад гацаад 1 сар, 18.3 хувь 1-3 сар, 55.1 хувь нь 3-6 сар, 21.4 хувь нь 6 сараас дээш хугацаагаар эх орондоо буцаж ирж чадахгүй гацсан гэж тус тус хариулжээ⁴¹.

2020.12.18-ны өдрийн Улаанбаатар-Франкфурт чиглэлийн нислэгээр ирсэн 160 иргэн, 2020.12.20-ны өдрийн 160 иргэний шалтгаан тодорхойгүй байгаа тул графикт багтаагаагүй болно.


⁴¹ Эх сурвалж: <https://covid19-2cdarkhan.opendata.arcgis.com>

4.1.1 Гадаадад байгаа иргэдийг авч ирэх ажиллагаатай холбоотой шийдвэр, арга хэмжээ

2020 оны 7 дугаар сарын байдлаар УОК-ын Шуурхай штабт гадаадад байгаа иргэдийг тээвэрлэх ажиллагаатай холбоотойгоор 13,000 гаруй өргөдөл гомдол, мэдээлэл ирсэн байна. Үүнээс тээвэрлэх ажиллагааны үйл явцыг иргэдэд ил тод, нээлттэй болгох талаарх өргөдөл, гомдол багагүй хувийг эзэлж байсан тул УОК-оос иргэдийн гомдол мэдээлэл бүрт хариу өгч шийдвэрлэх, нийтэд зарлах, гадаад дахь дипломат байгууллагуудад иргэдийн гаргасан хүсэлт, дарааллыг ямар нэг хэлбэрээр ил тод байрлуулах, иргэн өөрийн дарааллыг харах боломжтой болгох зэргээр менежментийн өөрчлөлт хийсэн нь сайшаалтай⁴². УОК-оос хэрэгжүүлж байгаа тусгай үүргийн нислэгийн хүрээнд 2020 оны 11 дүгээр сар хүртэлх эх орондоо ирсэн иргэд болон тусгай үүргийн нислэгийн тоог сар тус бүрээр задалж График 3-т харуулав.

График 3.

Агаарын болон авто замаар ирсэн иргэдийн тоо, тусгай үүргийн нислэгийн тоо



(Эх сурвалж: Гадаад харилцааны яам, бусад мэдээллийн хэрэгсэл)

⁴² Эх сурвалж: <https://ikon.mn/n/1xv2>

Дээрх графикаас үзвэл, 2020 оны 7-10 дугаар саруудад тусгай үүргийн нислэг хамгийн олон удаа үйлдэгдсэн бол 1-5 дугаар саруудад харьцангуй бага нислэг үйлдэгджээ. УОК-оос гадаадад байгаа иргэдийг татан авах ажиллагааг Монгол Улс дахь халдварын нөхцөл байдал, тусгаарлах байрны хүрэлцээ хангамж, халдварт өвчний дэглэм сахилт зэрэг дотоодын хүлээн авах чадварт нийцүүлэн хэрэгжүүлж байгаа хэмээн тайлбарлаж байгаа⁴³. Эндээс дүгнэвэл, тусгай үүргийн нислэг бага үйлдэгдсэн саруудад дотоодын хүлээн авах чадвар сул байсан гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, тусгай үүргийн нислэгийн тоо, тухайн нислэгээр ирэх иргэдийн тоог дотоодын хүлээн авах чадвартай шууд хамааралтай гэж үзвэл эмнэлгийн ор, тусгаарлах байрны хүрэлцээ бага тохиолдолд нислэг болон нислэгээр ирэх иргэдийн тоо буурах хамааралтай байна.

Гэвч цар тахлын үед эмнэлгийн ор, тусгаарлах байрны хүрэлцээ бага гэх мэт дотоодын хүлээн авах чадвар сул байх нь гадаадаас эх орондоо ирэх Монгол Улсын иргэний эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлах үндэслэл болох учиргүй. Учир нь Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.15-д зааснаар Засгийн газар цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой зардлыг шийдвэрлэх үүргийг хүлээнэ. Ийнхүү Монгол Улсын Засгийн газар цар тахлын үед гадаадад байгаа иргэдийг эх оронд нь авч ирэх, хүлээн авахтай холбоотой бэлэн байдлыг хангаж, хариу арга хэмжээг авахад шаардлагатай нөөцийг бүрдүүлэх үүрэгтэй.

Мөн цар тахлын онцгой нөхцөл байдлын үед гадаадаас эх орондоо ирж байгаа бүх иргэн зардлаа өөрсдөө хариуцах нь оновчгүй бөгөөд төр зарим тохиолдолд эрсдэлийг үүрэх чадамжтай байх ёстой. Тухайлбал, гадаадад байгаа зарим иргэн түр хугацаагаар яваад төлбөрийн чадамжгүй болсон зэргээр иргэд төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд төр тухайн эрсдэлээс нь үүрэлцэх шаардлагатай

⁴³ Синдикат ярилцлага #52, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Б.Ууганбаяр, (<https://ikon.mn/opinion/1y32>)

юм⁴⁴. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын иргэн “эд, мөнгөний тусламж авах эрхтэй” энэ эрхээ эдлэх боломжоор нь хангах ёстой.

4.1.2 Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах тусгай сангийн зориулалт, хэрэгжилт

Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан нь Засгийн газрын тусгай санд хамаарах бөгөөд хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлэх, иргэний улсын бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зориулалттай⁴⁵. Уг сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Гадаад харилцааны сайд юм⁴⁶.

Тус сангийн зориулалт, ач холбогдлын талаар Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.6 дах хэсэгт:

“Гадаад харилцааны салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэдэгт “Монгол Улс ...хилийн чанадад Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг улам сайжруулж, эх орноо гадаадад сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлнэ” гээд 5.6.9-д “Хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийнхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг тууштай хамгаалж, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлж, иргэний бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна. Энэ хүрээнд “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-гийн хөрөнгө, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж тусгасан байдаг⁴⁷.

⁴⁴ “Хуульч Д.Сүнжид: Төр гадаадаас авчирч буй иргэдээ бүх зардлаа өөрсдөө хариуц гэх нь оновчгүй” ярилцлага, Ulaanbaatar news, 2020 оны 5 дугаар сарын 27 (<https://ubn.mn/p/3655>)

⁴⁵ 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1

⁴⁶ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, танилцуулга, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, хууд. 8

⁴⁷ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газраас хилийн чанадад эрх ашиг нь хохирсон, төлбөрийн чадваргүй болсон Монгол Улсын иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм”-ийг шинэчлэн баталсан. Тус дүрмийн 2.1 дэх хэсэгт зааснаар сангийн хөрөнгийн эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгө болон гадаад улс, олон улсын байгууллага болон гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгсөн буцалтгүй тусламж, хандиваас бүрдэхээр зохицуулжээ. 2017-2019 оныг хүртэлх хугацаанд Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн зардлыг дараах байдлаар төлөвлөж, гүйцэтгэжээ.

Хүснэгт 1.

Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн төсөв, зарцуулалт

Он	Батлагдсан	Гүйцэтгэсэн	Хувь	Зөрүү
2017	224,000.0	223,143.6	99.6	-856.4
2018	224,000.0	224,000.0	100	0.0
2019	224,000.0	224,000.0	100	0.0

(Эх сурвалж: 2017-2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл)

Үүнээс өнгөрсөн жил буюу 2019 онд тус сангийн нийт төсвийн 50 хувийг гадаадад нас барсан иргэнийг эх оронд нь авч ирэхэд зарцуулж, мөн гадаадад ял эдэлж байгаа иргэдийг эргэж очих, эх оронд нь авч ирэхэд тодорхой хувийг зарцуулжээ. Энэ зарцуулалтыг тайлбарлахдаа сангийн хөрөнгийг хэрхэн зарцуулах хувь хэмжээг зохицуулсан томьёолол байгаагүй хэмээжээ⁴⁸.

тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

⁴⁸ “Хилийн чанадад байгаа монгол иргэдэд туслах сан байгуулна” мэдээ, <https://montsame.mn/mn/read/204888>

2020, 2021 онуудад Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах санд 200 орчим сая төгрөгийг тус бүр төлөвлөсөн байх⁴⁹ бөгөөд одоогийн дагаж мөрдөгдөж байгаа хуулиар тус сангийн хөрөнгийг дараах найман арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулахаар зохицуулжээ. Үүнд:

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

17.2. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2, 6.2.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

17.3. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

17.3.1. хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарил буюу чандрыг эх оронд нь авчрах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах;

17.3.2. хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, терроризм, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах;

17.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэн эх орондоо буцах зардалгүй тохиолдолд эх оронд нь буцаах;

17.3.4. гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах;

17.3.5. энэ хуулийн 17.3.1, 17.3.2, 17.3.3, 17.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;

⁴⁹ Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн төсөл, танилцуулга, 40-р тал, Монгол Улсын нэгдсэн төсөв 2021, 36-р тал

- 17.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль, хяналтын байгууллагаар шалгуулах, хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;
- 17.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг Дипломат төлөөлөгчийн газраас эргэх;
- 17.3.8. гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх олон улсын гэрээнд заасан Монголын талын эрх бүхий төрийн байгууллагаас гадаад улсад хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт болон холбогдох баримт бичгийг гадаад хэл рүү орчуулах төлбөрийг гаргах.

2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас (ДЭМБ гэх) Ковид-19 халдварын тархалт, хамрах хүрээ, эрсдэл зэргийг харгалзан үзэж, эпидеми буюу тахлын хүрээнээс хальж пандеми буюу цар тахлын хэмжээнд хүрснийг албан ёсоор зарласан. 2020 оны 12 дугаар сарын байдлаар дэлхий даяар нийт 67.5 сая хүн халдвар авч, үүнээс 1.5 сая хүн амь насаа алдсан статистик байна⁵⁰.

Иймд дэлхий даяар коронавируст халдвар буюу цар тахал улам нэмэгдсээр байгаа өнөөгийн нөхцөл байдалд гадаадад байгаа бага насны хүүхэдтэй гэр бүл, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, эрүүл мэндийн шалтгаантай, тусгай хэрэгцээт иргэд болон бусад шалтгаантай иргэдийн амь насанд аюул учраад байна. Хэрэв гадаадад байгаа иргэд халдвар авбал халдварыг эмчлэхэд шаардагдах зардал, бусад зардлаас үүдэн тухайн иргэн болон тэдний гэр бүлийн санхүүгийн хүндрэл бэрхшээл улам нэмэгдэж, цаашлаад эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах эрсдэлтэй.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17.3.2, Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрмийн 4.3.2 дахь заалтын дагуу коронавируст цар тахлын үед сангийн хөрөнгийг санхүүгийн хүндрэл бэрхшээл болон бусад шалтгаанаар гадаадаас эх орондоо буцаж чадахгүй байгаа иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ

⁵⁰ (<https://www.worldometers.info/coronavirus/>)

үзүүлэх, эх оронд нь буцаах үйл ажиллагаанд зарцуулах ёстой. Үүнийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Шадар сайдын “Хөрөнгө гаргах тухай” 2020 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 85 дугаар тушаалаар дэлхий даяар тархсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед хилийн чанадад байгаа тодорхой шалгуурыг хангасан зорилтот бүлгийн Монгол Улсын иргэнд зориулан 300,000,000 (гурван зуун сая) төгрөгийг УОК-т хандивласан хандивын хөрөнгөнөөс олгож, Гадаад харилцааны яамны Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах санд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Харин 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Монгол Улсын Гадаад харилцааны сайдын “Хөрөнгө гаргах тухай” А/45 дугаар тушаалаар нэр бүхий 113 иргэнд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх зорилгоор нийт 117,424.700 (нэг зуун арван долоон сая дөрвөн зуун хорин дөрвөн мянга долоон зуу) төгрөгийг дээрх сангаас зарцуулжээ. Ингэхдээ Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрмийн 4.3.1, 4.3.2 дахь заалтад тус тус үндэслэн⁵¹ хилийн чанадад нас барсан зарим иргэний шарил буюу чандрыг эх оронд нь авч ирэх, нэр бүхий цөөн тооны иргэний нутаг буцах зардал, тусгаарлах байрны төлбөрийг тус тус санхүүжүүлэхэд зарцуулжээ.

Төрийн санхүүгийн дэмжлэгийн зэрэгцээ Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлөөс “Эх орондоо маск илгээцгээе” аяныг санаачлан өрнүүлж, эх орондоо амны хаалт хандивлахын зэрэгцээ гадаадад байгаа санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй, орон байр, хоол хүнсгүй болсон иргэдэд зориулан санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлсэн байгаа нь талархууштай⁵².

Ийнхүү гадаад улсаас эх орондоо ирж байгаа иргэдийн 60 орчим хувийг санхүүгийн хүндрэл, бэрхшээлтэй хүмүүс эзэлж байгаагаас үзвэл, коронавируст цар тахлын онцгой үед гадаадад байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор гадаадад хүндрэл, бэрхшээлд ороод байгаа иргэдийг яаралтай судлан тогтоож, нэн тэргүүнд эх оронд нь авч ирэх, авч ирэх боломжгүй түр хугацаанд тэнд нь зохих тусламж, дэмжлэг үзүүлэх, Хилийн чанадад байгаа Монгол

⁵¹ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17.3.1, 17.3.2 дахь заалтууд нь Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрмийн 4.3.1, 4.3.2 дахь заалттай агуулга, бичвэрийн хувьд ижил.

⁵² Эх сурвалж: (<http://consul.mn/images/pictures/mongolirgedhandiv1597224850.pdf>)

Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгө хүрэлцэхгүй бол нэмэгдүүлэх зэргээр ажиллах ёстой аж.

4.2 Монгол Улсаас Гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Консулын газраас гадаадад байгаа иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээ

Дипломат төлөөлөгчийн газар нь Дипломат албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь хэсэгт зааснаар “хилийн чанадад Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах” 7.1.7 дахь хэсэгт зааснаар “суугаа болон хавсран суугаа оронд нь амьдарч буй Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдэнд эд материал, санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлэх” чиг үүрэгтэй.

Мөн Монгол Улсын Консул нь Монгол Улсын Консулын дүрэмд заасны дагуу дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 71-р тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Консулын дүрэм

Нэг. Консулын албаны зорилт, зохион байгуулалт, бүрэлдэхүүн

1. Монгол Улсын консулын алба нь дипломат албаны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хилийн чанадад Монгол Улс, түүний иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй байгууллага мөн.

Дөрөв. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбогдсон асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1. Консул нь Монгол Улсын болон суугаа улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээг даган мөрдөж, олон улсын зан заншлын хэм хэмжээг хүндэтгэн, Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
2. Консул иргэний өргөдөл, хүсэлт, гомдлыг бичгээр хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
3. Консул нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах арга хэмжээ авна.

Ковид-19 хуулийн 7.1.12 болон 7.1.22 дахь хэсэгт тус тус заасны дагуу коронавируст цар тахлын үед Монгол Улсын Засгийн газраас гадаадад байгаа орон гэргүй иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах, хүүхэд болон өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хамгийн түрүүнд авч ажиллах үүрэгтэй.

Монгол Улсаас Гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Консулын газраас гадаадад байгаа иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлсэн эсэх асуудлыг тодруулах үүднээс цахим сүлжээн дэх “Гадаадад гацсан Монголчууд (Covid-19)” нэгдсэн группт “Танд Монгол Улсаас гадаадад суух Элчин сайдын яам, газраас ямар нэг бодит тусламж үйлчилгээ үзүүлсэн үү?” гэсэн томьёоллоор асуулгын судалгаа явуулахад, нийт 82 иргэн оролцсоноос 78 иргэн “Үгүй”, 4 иргэн “Тийм” гэсэн хариултыг тус тус ирүүлсэн байна.⁵³ Үүнээс “Тийм” гэсэн хариултыг ирүүлсэн нэр бүхий иргэнээс тодруулга авахад тухайн иргэний оршин суугаа улсын (Франц, Турк зэрэг) консулын ажилтны зүгээс “утсаар ярихад бүрэн сонсож, асуудлыг шийдэж өгсөн”, “нэрээ өгсөн хүмүүсийн мэдээллийг сайт дээрээ ил тод тавьж, тухай бүр шинэчилж байсан”, “онгоцны буудал дээр иргэддээ сэтгэл гаргасан”, “Франкфуртад гацаад Францаас 2 охиноо авч чадахгүй нислэг байхгүй байхад надад 2 охинтой минь буцах боломж олгосон” хэмээн хариулсан.

Гэсэн хэдий ч дээрх асуулгад оролцогчдын 95 хувь тусламж, үйлчилгээ огт үзүүлээгүй хэмээн хариулсан байна. Тухайлбал, Швед Улсад коронавирусээр өвчлөөд эдгэрсэн иргэн Ч.Ө нь хэвлэлд өгсөн ярилцлагадаа:

“Ч.Ө: ... гуравдугаар сарын 25-аас эхлэн маш өндөр халуурч, үе мөчөөр янгинаж, үнэр, амт мэдрэхээ больсон. Тэр үед үнэхээр хүнд байсан. Хүн болж төрснөөсөө хойш анх удаа л тийм их өвдөлтийг мэдэрч үзсэн. Халуун буулгах эм, гоожуурын хүйтэн ус уугаад л байдаг байсан. Сүүлдээ өндийх ч тэнхэлгүй болж, толгой эргэж, их сульдсан. Их хөлөрснөөс болж орны даавуу, хөнжил бүхэлдээ норж байсан. Гэсэн хэдий ч солих хөнжил, туслах хүн байхгүй учраас нойтон хөнжлөө хаттал нь чичирч хэвтдэг байсан.

⁵³ Судалгааны тандалтын хугацаа 2020.11.20-11.25-ны өдөр хүртэл.

Сэтгүүлч: Швед дэх элчин сайдын яаманд хандаж, тусламж хүссэн үү?

Ч.Ө: Элчин сайдын яаманд хоёр удаа хандсан ч “Монголоос зөвлөгөө ав, бид нар мэдэхгүй” гэсэн хариу л өгсөн.

Сэтгүүлч: Та тусгай үүргийн онгоцонд багтаагүй юм уу. Ирэх арга замаа судалж үзсэн үү?

Ч.Ө: Би анх хүсэлтээ дөрөвдүгээр сарын 20-нд өгсөн. Бас зургаадугаар сарын 22-нд дахин өгсөн. Таван шаардлага байгаа ч би алинд нь ч багтахгүй. Гэхдээ маш их гомдолтой байгаа. Би ч гэсэн эх хүн. Миний ард амьдрал минь, хоёр хүүхэд минь байгаа. Бас би хүний нутагт үхээд сэхсэн хүн. Сэтгэл зүйн хувьд хүнд байна. Тэгэхээр онгоцонд багтахгүйгээс хойш ингэж хүлээж суумааргүй байгаа болохоор газраар дамжиж явах боломжийг судалж байна. Бас санхүүгийн хувьд ч боломжгүй учраас зээл тавиад ч хамаагүй явахыг хүсэж байна”⁵⁴ гэжээ.

Ийнхүү Монгол Улсаас Гадаад улсад суух Элчин сайдын яам, Консулын газраас гадаадад байгаа иргэдэд санхүүгийн болон эд материалын бодитой тусламж, үйлчилгээ үзүүлсэн жишээ, баримт хангалттай харагдахгүй байна.

4.3 Явцын дүгнэлт

Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах үүднээс гадаадад байгаа Монгол Улсын иргэдийг эх оронд нь авч ирэх ажлыг хугацаа алдалгүй, нэн даруй хэрэгжүүлж дуусгах ёстой. Үүний тулд тусгаарлах байрны тоо, эмнэлгийн хэрэгсэл, эмч, эмнэлгийн ажилтнууд, бусад төрийн албан хаагчдын хүний нөөц зэрэг дотоодын хүлээн авах чадварыг эн тэргүүнд яаралтай нэмэгдүүлж, аюулгүй байдал, зохион байгуулалтын үйл ажиллагааг чанд мөрдөж, хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Нөгөө талаас Монгол Улсаас Гадаад улсуудад суугаа Элчин сайдын яам, Консулын газраас “Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдэнд эд материал, санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлэх” чиг үүргийнхээ хүрээнд гадаадад байгаа санхүүгийн болон бусад хүндрэл шалтгаантай иргэдийн тооцоо судалгааг бодитойгоор гаргаж, шаардлагатай иргэдэд санхүүгийн болон эд материалын тусламж, дэмжлэг үзүүлэх замаар гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэн ажиллах ёстой.

⁵⁴ 2020 оны 7 дугаар сарын 6-ны өдөр, (<http://isee.mn/n/11331>)

ТАВ. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

5.1 Европын холбооны туршлага

2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Европын комиссоос “Эрүүл мэндийг хамгаалах, бараа бүтээгдэхүүн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний хүртээмжийг хангах хилийн арга хэмжээний удирдамж”-ийг баталсан. Уг удирдамжид “Гишүүн улс орнууд өөрсдийн иргэд, оршин суугчдын эх нутагтаа ирэх явдлыг үргэлж хүлээн зөвшөөрч, Европын Холбооны бусад иргэд, оршин суугчдын хилээр дамжин өнгөрөх ажлыг хөнгөвчлөх ёстой” гэж тусгасан байна. Харин халдварын шинж тэмдгүүд илэрсэн буюу халдвар авах эрсдэл бүхий гуравдагч орны, оршин суугч бус иргэдийг нийтийн эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл хилээр нэвтрүүлэхээс татгалзаж болно гэжээ.

Дээрх удирдамжид Гишүүн улс орнууд нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор бараа бүтээгдэхүүн болон зорчигч тээвэрлэлтийн хөдөлгөөнд хязгаарлалт хийх тохиолдолд:

- Ил тод буюу нийтийн баримт бичигт тусгасан байх;
- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Европын өвчнөөс урьдчилан сэргийлэх төвөөр дэмжигдсэн шинжлэх ухааны үндэслэлтэй байх;
- Тухайн нөхцөлд тохирсон буюу зайлшгүй байх;
- Хязгаарлалт нь тухайн тээвэрлэлтийн төрөл, горимд тохирсон байх;
- Ялгаварлан гадуурхаагүй байх гэж тус тус заасан байна⁵⁵.

Мөн 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр эрүүл мэнд, хоол хүнс, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт болон бусад шаардлагатай салбар, үйлчилгээний нийт 15 байгууллагад ажилладаг албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой хилээр зорчих хөдөлгөөнийг дэмжин ажиллах ёстой хэмээн шийдвэрлэжээ. Хэрэв эдгээр албан хаагчийн

⁵⁵ Covid-19 Guidelines for border management measures to protect health and ensure the availability of goods and essential services 2020/C 86 I/01

хилээр зорчих хөдөлгөөнийг хязгаарлах бол тухайн хязгаарлалт нь нийтийн бодлого, нийтийн аюулгүй байдал болон эрүүл мэндийг хамгаалах зорилготой байх, тухайн нөхцөлд тохирсон буюу зайлшгүй байх, объектив байх, ялгаварлан гадуурхаагүй байх шаардлагыг хангах ёстой гэжээ⁵⁶.

2020 оны 6 дугаар сарын байдлаар Америк, Ази Номхон далай, Европ, Төв Ази, Зүүн өмнөд ба Хойд Америк зэрэг тивүүдэд эх орондоо буцах шаардлагатай 600,000 гаруй иргэн байсан бөгөөд үүнээс 590,000 гаруй иргэн эх орондоо аюулгүй буцаж ирээд байна. Түүнчлэн Европын холбооноос гадаадад байгаа иргэдийг татан авах зорилгоор “*WeTakeYouHome*” гэх уриалга санаачилж, *European Union Civil Protection Mechanism (UCPM)* буюу “Европын Холбооны Иргэдийг Хамгаалах Механизм”⁵⁷-ын хүрээнд 270 удаагийн нэмэлт нислэгээр 60,000 гаруй иргэнийг татан авах ажлыг зохион байгуулсан. Энэ талаар *The European External Action Service (EEAS)* буюу “Европын харилцааны алба”-наас иргэдийг татан авах ажиллагаанд нэмэлт 45 сая еврогийн тусламж үзүүлэх боломжтой талаар илэрхийлж, энэ удаагийн татан авах ажиллагаа нь аялал, албан ажлын шугамаар гадаадад явж байгаад гацсан иргэдэд чиглэгдэнэ, харин гадаадад байнга оршин суугч иргэдэд хамаарахгүй гэжээ⁵⁸.

5.2 Япон Улсын туршлага

Япон Улсад 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр анхны халдварын тохиолдол батлагдсан бөгөөд 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр “Шинэ төрлийн ханиад, томууны үед авах тусгай арга хэмжээний тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулиар зохицуулах харилцаанд шинэ төрлийн коронавируст халдварыг нэмсэн. Энэ нэмэлтийн гол агуулга нь шинэ төрлийн коронавирусийн халдвар ард иргэдийн амьдрал, нийгэм,

⁵⁶ Communication from the Commission Guidelines concerning the exercise of the free movement of workers during COVID-19 outbreak 2020/C 102 I/03

⁵⁷ European Union Civil Protection Mechanism (UCPM) нь Европын холбооны гишүүн улс орнууд болон бусад оролцогч улс орны иргэний хамгааллын чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээг сайжруулах зорилготой.

⁵⁸ https://eeas.europa.eu/headquarters/headquarters-homepage/76203/good-stories-consular-support-eu-citizens-stranded-abroad_en

эдийн засагт үзүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилготой байна⁵⁹.

2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр Шинэ төрлийн ханиад, томууны үед авах тусгай арга хэмжээний тухай хуулийн 32 дугаар зүйлд үндэслэн халдварын улмаас иргэдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр долоон муж, хотын (Сайтама, Чива, Токио, Канагава, Осака, Хёого, Фүкүока) хэмжээнд шинэ төрлийн томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн⁶⁰. Ийнхүү 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд тогтоосон бэлэн байдлын зэргийг хоёр удаа хэсэгчлэн цуцалж, 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн цаашид бэлэн байдлын зэргийг тогтоох шаардлагагүй хэмээн үзэж, шийдвэрийг цуцалсан байна⁶¹.

Бэлэн байдлын зэрэгт шилжих урьдчилсан нөхцөлийг задалж үзвэл, нэгдүгээрт тухайн халдвар нь Засгийн газрын шийдвэрээр баталсан иргэдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй халдвар мөн байх, хоёрдугаарт дотооддоо халдвар бүртгэгдсэн байх, гуравдугаарт тухайн халдвар нийт улсын хэмжээнд хурдацтай тархсаны улмаас иргэдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй эрсдэлтэй байх гэсэн нөхцөлтэй⁶².

2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Япон Улсын Засгийн газрын тэргүүнээр ахлуулсан “Шинэ төрлийн коронавируст халдвартай тэмцэх төв штаб”-ыг байгуулж, тус төв штабын шийдвэрээр дээрх гурван нөхцөлийг хангасан хэмээн үзэж, бэлэн байдал тогтоосон байна. Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд муж, хотуудын Засаг дарга, захиргаанаас иргэдийг яаралтай биш буюу онцын шаардлагагүй бол гадагш гарахгүй байх, сургууль, олон нийтийн байгууламжийн хэрэглээ, ашиглалтыг хязгаарлах, түр зогсоохыг уриалж ажиллажээ. Гэвч үүний

⁵⁹ <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=424AC0000000031>,
<https://www.fdma.go.jp/laws/tutatsu/items/0316jimurennraku.pdf>

⁶⁰ Гэвч халдварын тохиолдол эрс нэмэгдэж байсан тул 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр 40 муж, хотыг нэмж, улсын хэмжээнд бэлэн байдалд шилжсэн.

⁶¹ Шинэ төрлийн коронавирусийн халдварын бэлэн байдлын зэрэгт шилжсэн нөхцөл байдлын талаарх тайлан, https://corona.go.jp/news/pdf/kinkyujitaisengen_houkoku0604.pdf

⁶² https://www.jda.or.jp/dentist/coronavirus/upd/file/20200413_coronavirus_kinkyujitaisengen_kihontekitaisyohousin49.pdf

улмаас иргэдийн зорчих, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хөдөлмөрлөх эрх болон хүүхдийн сурч боловсрох эрх зэрэг хүний эрх хязгаарлагдах үр дагавартай болохыг зарим судлаачид сэрэмжлүүлж байжээ⁶³.

Шинэ төрлийн ханиад, томууны үед авах тусгай арга хэмжээний тухай хуульд халдвараас урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалж, иргэдийн амьдрал, нийгэм, эдийн засагт замбараагүй байдал үүсэхээс зайлсхийх зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл хүний зарим эрхэд хязгаарлалт тогтоохыг зөвшөөрсөн. Тухайлбал, тус хуулийн 5 дугаар зүйлд “Иргэдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэх үзэл санааны үүднээс шинэ төрлийн томуу, томуу төст өвчний талаар авах арга хэмжээний хүрээнд иргэдийн эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоох бол энэ нь тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй бөгөөд хамгийн бага байх ёстой” гэж заажээ⁶⁴. Өөрөөр хэлбэл, шинэ төрлийн коронавиуст халдварын үед хэрэгжүүлэх шийдвэр, арга хэмжээний үр дүнд хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдах боломжтой ч энэ нь халдвараас урьдчилан сэргийлэх зорилгыг хангахад зайлшгүй бөгөөд хамгийн багаар хязгаарласан байх ёстой гэсэн агуулгатай⁶⁵. Энэ талаар Япон Улсын Өмгөөлөгчдийн холбоо, зарим судлаачийн зүгээс дээр дурдсан “халдвараас урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалж, иргэдийн амьдрал, нийгэм, эдийн засагт замбараагүй байдал үүсэхээс зайлсхийх зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл” гэсэн хүний эрхэд хязгаарлалт тогтоох нөхцөл нь ерөнхий буюу тодорхой бус, мөн хязгаарлалтын хугацаа нь 3 жил (дээд хугацаа нь 2 жил байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл 1 жилээр сунгаж болно)⁶⁶ байгаа нь хүний эрхийг хэтрүүлэн хязгаарлах үр дагавартай байна гэдгийг онцлон сануулсан байна⁶⁷.

⁶³ 志田陽子「緊急事態宣言と「集会の自由」——「表現の自由」のために今「自粛」を呼びかける理由」(<https://news.yahoo.co.jp/byline/shidayoko/20200407-00171865/>)

⁶⁴ <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=424AC0000000031>

⁶⁵ <http://www.yama-ben.jp/statement/1290/>

⁶⁶ Шинэ төрлийн томуу, томуу төст өвчний үед авах тусгай арга хэмжээний тухай хуулийн 32.2, 32.4 дэх заалт

⁶⁷ Япон Улсын Өмгөөлөгчдийн холбооноос хуулийн төсөлд өгсөн санал, 2012 оны 3 дугаар сарын 9, <https://www.nichibenren.or.jp/document/statement/year/2012/120322.html>, Яаманаши мужийн Өмгөөлөгчдийн холбоо, 2020 оны 3 дугаар сарын 17, <http://www.yama-ben.jp/statement/1290/>

2020 оны 3 дугаар сарын 6-ны өдөр Япон Улсын Засгийн газрын хуралдаанаар коронавируст халдварын үед хилийн арга хэмжээг чангатгаж ажиллах үндсэн чиглэлийг баталсан. Энэ хүрээнд БНХАУ болон Бүгд Найрамдах Солонгос улсуудаас ирэх бүх хүнд хязгаарлалт тогтоож, харин түүнээс бусад улсаас нэвтрэх хүмүүсийг шаардлагатай бол эмнэлэгт хэвтүүлэх, тусгаарлахаас гадна бүх хүнийг гэртээ 14 хоногийн хугацаанд байхыг уриалсан байна⁶⁸. Гэвч 4 дүгээр сарын 1-ний өдөр коронавируст халдварын цар хүрээ нэмэгдсэнтэй холбоотойгоор Индонез тэргүүтэй Зүүн өмнөд Азийн 49 улсаас ирэх зорчигчдод хилийн хязгаарлалт тогтоосон хэдий ч, үүнд Япон Улсын иргэн болон байнгын оршин суух тусгай эрх бүхий гадаадын иргэн, түүний эхнэр, нөхрийг хамааруулаагүй байна. Хилээр шалган нэвтрүүлэх ба Дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх тухай хуульд Япон Улсын иргэн болон гадаадын харьяат иргэдийн хилээр нэвтрэх процесс, журмыг ялгаатай зохицуулсан байх бөгөөд Япон Улсын иргэн мөн л бол эх орондоо буцаж ирэхэд нь саад учруулахгүй хэмээн зохицуулжээ⁶⁹. Тодруулбал, тус хуулийн 61 дүгээр зүйлд “Япон Улсын нутаг дэвсгэрт үл хамаарах газраас Японд буцаж ирсэн Япон Улсын иргэн (онгоцны багийн гишүүдээс бусад) хүчин төгөлдөр паспорт авч явах (хүчин төгөлдөр паспорт авч явах боломжгүй бол Япон Улсын харьяалалтай болохыг нотлох баримт бичиг) бөгөөд цагаачлалын байцаагч Хууль зүйн яамнаас тогтоосон журмын дагуу буцаж ирснийг заавал баталгаажуулах ёстой” гэж заасан.

Үүнээс үзвэл, Европын холбоо болон Япон Улс цар тахлын үед өөрийн улсын харьяат иргэдийнхээ эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлаагүй байгаа нь Монгол Улсын нөхцөл байдлаас ялгаатай байна.

⁶⁸ https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000121431_00098.html

⁶⁹ Япон Улсын Цагаачлалын агентлагаас хуулийн 61 дүгээр зүйлийн тайлбар, <http://www.immi-moj.go.jp/tetuduki/kanri/kikoku.html>

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ

6.1 Дүгнэлт

1. Эх орондоо буцаж ирэх эрх нь онц болон дайны байдал зарласнаас бусад тохиолдолд дур зоргоор хязгаарлаж үл болох, жам ёсны шинжтэй онцгой эрх юм. Хэрэв цар тахал зэрэг нэн ховор онцгой нөхцөл байдлын үед хязгаарлах тохиолдолд энэ нь тодорхой үндэслэлтэй байх ёстой гэдгийг Хүний эрхийн хорооны тайлбарт тэмдэглэжээ. Манай улсын хувьд Ковид-19 хуульд коронавируст халдварын цар тахлын үед хүний зарим эрхийг хязгаарлахад тавигдах шаардлага, үндэслэлийг нэг бүрчлэн тусгасан. Хэдий тийм боловч Монгол Улсын Засгийн газраас хилийн хориг тогтоосон шийдвэр, арга хэмжээ нь дээрх хуульд заасан шаардлага, үндэслэлүүдийг нэг мөр хангаж чадаагүй байх тул Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12.4 дэх хэсэгт заасан “дур зоргын (*arbitrarily*)” шинжтэй байна.
2. Судалгаагаар коронавируст халдварын цар тахлын үед гадаадаас эх орондоо ирсэн болон эх орондоо буцах хүсэлт гаргасан нийт иргэний 60 орчим хувийг санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй иргэд эзэлж байгаагаас үзвэл, Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгө нь нэн тэргүүнд санхүүгийн хүндрэл, бэрхшээлтэй иргэдэд зориулагдах шаардлагатай болохыг харуулж байна. Гэвч энэ хугацаанд тус санг захиран зарцуулах эрхтэй Гадаад харилцааны сайд Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах тусгай санд төвлөрүүлсэн хөрөнгийг гадаадад байгаа санхүүгийн хүндрэл, бэрхшээлтэй бүх иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрсдэлийг бууруулах зорилгоор нэмэгдүүлж, бүрэн зарцуулах талаар Засгийн газрын хуралдаанд санал оруулах байдлаар идэвхтэй ажиллаагүй.
3. Монгол Улсын Засгийн газар цар тахлын үед гадаадад байгаа иргэдийг эх оронд нь авч ирэх, хүлээн авахтай холбоотой бэлэн байдлыг хангаж, хариу арга хэмжээ авахад шаардлагатай нөөцийг

бүрдүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн. Нөгөө талаас Монгол Улсаас Гадаад улсад суугаа Элчин сайдын яамд, Консулын газрууд “Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдэнд эд материал, санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлэх” чиг үүргийнхээ хүрээнд гадаадад байгаа санхүүгийн болон бусад хүндрэл шалтгаантай иргэдийн тооцоо судалгааг бодитойгоор гаргаж, шаардлагатай иргэдэд санхүүгийн болон эд материалын тусламж, дэмжлэг үзүүлэх замаар гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэн ажиллаагүй. Ялангуяа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд ноцтой сөрөг нөлөө учруулахуйц шийдвэрийг урьдаас төлөвлөхгүйгээр гэнэт гаргаж, өөрчилж байгаа нь иргэдэд чирэгдэл учруулж, эд материалын болоод сэтгэл санааны хүнд байдалд оруулж байна.

6.2 Санал

- Монгол Улсын Засгийн газраас гаргасан хилийн хориг тогтоосон шийдвэр нь Ковид-19 хуульд заасан хүний эрхийг хязгаарлахад тавигдах шаардлагуудыг нэг мөр хангаагүй байна. Иймд гадаадад байгаа иргэдийг авч ирэх ажлыг цаг алдалгүй үе шаттайгаар хэрэгжүүлж, Монгол Улсын иргэдийн эх орондоо буцаж ирэх эрхийн зөрчлийг нэн даруй залруулах;
- Монгол Улсын Засгийн газар цар тахлын үед эх орондоо буцах хүсэлт гаргасан иргэдийг эх оронд нь авч ирэх, хүлээн авахтай холбоотойгоор тусгаарлах байрны хүрэлцээг нэмэгдүүлэх, тусгаарлах байрны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгслийг төлөвлөх зэргээр дотоодын бэлэн байдлыг хангаж, цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахад шаардлагатай нөөцийг нэн даруй бүрдүүлэх;
- Нэгэнт нөөц боломжоос шалтгаалан буцаж ирэх хүсэлтэй бүх иргэнийг нэн даруй авч ирж чадахгүй байгаа тохиолдолд гадаад улс дахь Элчин сайдын яамд, Консулын газруудаараа дамжуулан орон гэргүй иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах зэрэг нэн шаардлагатай наад захын хэрэгцээгээр хангах, халдвараас

сэргийлэх ажлыг зохион байгуулах;

- Цар тахлын үед гадаадад байгаа санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй иргэдийн тооцоо, судалгааг тухай бүрд гаргаж, шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх;
- Гадаадад байгаа Монгол Улсын иргэдийг коронавирусийн халдварын улмаас ялгаварлан гадуурхалгүйгээр тусгай үүргийн нислэгт хамруулах боломжийг бүрдүүлэх.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх

1. 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 70 дугаар тогтоол.
2. 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Засгийн газрын 103 дугаар тогтоол.
3. 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын 159 дүгээр тогтоол.
4. Төрийн мэдээлэл, тусгай дугаар I дүгээр боть УБ., 2004 он.
5. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, танилцуулга, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо
6. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”.
7. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн төсөл, танилцуулга, Монгол Улсын нэгдсэн төсөв 2021 он.
8. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000 он.
9. Г.Совд Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (харьцуулсан эрх зүй)” УБ., 1999 он.
10. О.Мөнхсайхан “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт” Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, 2017 он.

Нийтлэл, ярилцлага

1. О.Мөнхсайхан: Хүний эрхийг хязгаарлах бол тодорхой шалгуурыг хангах ёстой” ярилцлага, Өнөөдөр сонин, 2020 оны 5 дугаар сарын 18.
2. “Г.Нарантуяа Гадаадад гацсан Монголчууд: Монгол Улсын Засгийн газар олон улсын эрх зүйн үүргээ зөрчсөн үү?” нийтлэл, 2020 оны 8 дугаар сарын 27, (<https://jargaldefacto.com/article/gadaadad-gatssan-mongolchuud-mongol-ulsiin-zasgiin-gazar-olon-ulsiin-erkh-zuin-uurgee-zurchsun-uu>).
3. “Хуульч Д.Сүнжид: Төр гадаадаас авчирч буй иргэдээ бүх зардлаа өөрсдөө хариуц гэх нь оновчгүй” ярилцлага, Ulaanbaatar news, 2020 оны 5 дугаар сарын 27 (<https://ubn.mn/p/3655>).

4. “Зууны мэдээ” сонин 2020 оны 8 дугаар сарын 3, № 155 (6380).
5. “Зууны мэдээ” сонин 2020.11.20 № 223 (6448).
6. “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас хилийн чанадад нас барсан зарим иргэний шарилыг чандарлах, эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсгийг санхүүжүүлсэн. Тухайлбал “Т.Нямцэрэн: Тусгай үүргийн онгоц хүлээж байгаад нас барсан аавын минь чандрыг дүү минь Монгол руу авч явна” ярилцлага, 2020 оны 9 дүгээр сарын 8 (<http://isee.mn/n/13179?fbclid=IwAR0fCyCEUQ3bx9XtRM1IDy-XrCvMy7P-0haU8Qb3uxNYnk6c-hyGNdM5MtQ>).
7. “Г.Эрдэнэзул: Найман хүн гадаадад гацах хугацаандаа нас барсан, энэ тоо өсөхөөс айж байна” ярилцлага, 2020 оны 8 дугаар сарын 3 (<http://itoim.mn/article/l6tLE/22901>).
8. Covid-19 халдварын тархалттай холбоотойгоор ОХУ, БНХАУ-аас хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд авч хэрэгжүүлж буй онцлог арга хэмжээ, хилийн боомтуудын үйл ажиллагааны талаарх Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын аюулгүй байдлын хэлтсийн ахлах офицер Н.Наранцогтын ярилцлага (<https://newswall.mn/?p=27031>).
9. Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудас, (<https://nema.gov.mn/n/108037>).
10. “Шведэд Монгол руу буцах хүсэлтэй 50 хүн маш хүнд нөхцөлд байна” (<https://news.mn/r/2375558/>), “Франкфурт-Улаанбаатар чиглэлийн тусгай үүргийн нислэг цуцлагдсанаас иргэд амьдрах газаргүй “болоод байна (<http://mongoltv.mn/post/56865>).
11. Гадаад харилцааны яамны Консулын газрын дарга Л.Мөнхтүшиг, <https://gogo.mn/r/v4ddd>.
12. Синдикат ярилцлага #52, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Б.Ууганбаяр, (<https://ikon.mn/opinion/1y32>).
13. “Хилийн чанадад байгаа монгол иргэдэд туслах сан байгуулна” мэдээ, <https://montsame.mn/mn/read/204888>.
14. “Гадаадад гацсан монголчуудын “арын хаалга”-тай нь чартер нислэгт багтаж байна”, 2020 оны 4 дүгээр сарын 23, (<http://zuv.mn/n29>).
15. “Гадаадад гацсан монголчууд: биелүүлэх ёстой учрал”, 2020 оны дугаар сарын 2, (<https://medium.com/altan-gurgaldai/гадаадад-гацсан-монголчууд-биелүүлэх-ёстой-учрал-298270b2fb5d>).
16. “Эгүүрийн сэдэв: Гадаадад гацсан иргэдээ гачлангүй татахыг хүлээсэн 10,600 зүрх”, 2020 оны 7 дугаар сарын 27, (<https://eguur.mn/125516/>).
17. “Г.Уянга: Гадаадад гацсан Монголчууд вирус биш”, 2020 оны 6 дугаар сарын 5, (<http://www.zaluucom.mn/read/4cg1g874a>).
18. “Б.Энхгэрэл: Гадаадад байгаа монголчууд онгоц, тусгаарлах байраа

- олсон ч УОК зөвшөөрөхгүй байна”, 2020 оны 7 дугаар сарын 10, (<http://npost.mn/a/168737>).
19. “Гадаадад гацсан элэг нэгтнүүдээ төлөөлж бичсэн захидал”, 2020 оны <http://posted.mn/c/letter-elegzurhneesuyatai>.
 20. “Хүний нутагт гацсан хүүхэд, эхчүүдээ хөсөр хаясан Монголын эмгэнэл” нийтлэл, Засгийн газрын мэдээ сонин, 2020 оны 5 дугаар сарын 28.
 21. Гадаад харилцааны Консулын газрын захирал Л.Мөнхтүшигийн ЭМЯ-ны хэвлэлийн бага хуралд өгсөн ярилцлага, (https://ikon.mn/n/225s?fbclid=IwAR2VTzMiYFem5M6mEgjly_0h_flj-b4quv8hrt2F91h-uxFejcthyYXR2c).
 22. “Сөүлээс энэ сарын 11, 12-нд ирэх байсан иргэд зочид буудал, халуун усны газраар хоноглож, хүнд нөхцөлд байна”, 2020 оны 11 дүгээр сарын 28, (https://gogo.mn/r/nd7w2?fbclid=IwAR0UcQjGjsyY2JaCj1kCnobmAgМЕН1NjRtAMQ_MMaKsrX1_vhB_gpyNK12Y).
 23. “Г.Мөнхшатар: Гадаадад хоноглох газаргүй, хоол ундгүй яваа олон монгол иргэн тусгай нислэг ирэхийг хүлээж байна”, 2020 оны 12 дугаар сарын 5, (http://itoim.mn/article/BXd3Q/24780?fbclid=IwAR17i6i-vdB1FGMlqSUMAB2mXsa5qhtdq_thsEx_xLzk7dq2fYw6F54az1o).
 24. “Гадаадад гацсан иргэд: Монгол буцах гээд байраа хүлээлгэн өгч, ажлаасаа гарсан иргэд халаасандаа сохор зоосгүй гудамжинд гарахад хүрээд байна”, 2020 оны 11 дүгээр сарын 17, (<http://isee.mn/n/15579>).
 25. “Тусгай үүргийн нислэгүүд цуцлагдаж, гадаадад гацсан 3800 иргэнээ яах вэ”, Зууны мэдээ сонин, 2020 оны 11 дүгээр сарын 20, (<http://www.zms.mn/a/81677>).
 26. “70 настай эмээтэйгээ ХБНГУ-ын оюутны байранд гацаад буй А.Долгорсүрэн манай редакцад хандлаа”, 2020 оны 11 дүгээр сарын 23, (<https://eguur.mn/155627/>).
 27. “Шведэд Монгол руу буцах хүсэлтэй 50 хүн маш хүнд нөхцөлд байна”, 2020 оны 11 дүгээр сарын 23, (<https://news.mn/r/2375558/>).
 28. “LIVE: Монгол буцах гээд байраа хүлээлгэн өгсөн иргэд халаасандаа сохор зоосгүй гудамжинд гарахад хүрээд байна”, 2020 оны 11 дүгээр сарын 23, (<https://livetv.mn/p/268561?fbclid=IwAR1mjLAW1pBGGX9iivCiCRIjzeVSUWydAiM2XZe5yOUTtF1UM3z97Gtt5Yw>).

Гадаад хэл дээрх

1. General Comment 27, CCPR/C/21/Rev.1/Add.9 of 2 November 1999.
2. United Nations Human Rights, Office of the High Commissioner “Emergency measures and Covid-19:Guidance” 2020.04.27 (<https://www>).

- ohchr.org/Documents/Events/EmergencyMeasures_COVID19.pdf).
3. Magna Carta, Ch. 42. (<https://constitutioncenter.org/learn/educational-resources/historical-documents/magna-carta>).
 4. H. Summerson, 'The 1215 Magna Carta: Clause 42, Academic commentary', The Magna Carta Project (http://magnacarta.cmp.uea.ac.uk/read/magna_carta_1215/Clause_42?com=aca).
 5. S.A.F. Jagerskiold, The freedom of Movement, in L. Henkin, (ed.) The International Bill of Rights, New York, Columbia University Press, 1981 p. 167-70.
 6. D.D.N. Nseroko, The Right to Return Home , in «Indian Journal of International Law», vol. 21, 1981, p. 336: “It is innate in human nature to yearn to be back home”.
 7. M. Cranston, The Political and Philosophical Aspects of the Right to Leave and to Return, in The Right to Leave and to Return: Papers and Recommendations of the International Colloquium Held in Uppsala, Sweden, 19-20 June 1972, New York, The American Jewish Committee, 1976, p. 28.
 8. G.J. Boling, The 1948 Palestinian Refugees and the Individual Right of Return: An International Law Analysis, Bethlehem, BADIL Resource Center for Palestinian Residency and Refugee Rights, 2001, p. 5.
 9. I. Brownlie, Principles of Public International Law, Oxford, Oxford University Press, 1990, p. 14-15.
 10. H. Hannum, The Right to Leave and Return in International Law and Practice, Dordrecht, Martinus Nijhof, 1987, p. 24.
 11. R. Aybay, The Right to Leave and the Right to Return: The International Aspect of Freedom of Movement, in «Comparative Law Yearbook», vol. 1, 1977, p. 127.
 12. Covid-19 Guidelines for border management measures to protect health and ensure the availability of goods and essential services 2020/C 86 I/01.
 13. Communication from the Commission Guidelines concerning the exercise of the free movement of workers during COVID-19 outbreak 2020/C 102 I/03.
 14. https://eeas.europa.eu/headquarters/headquarters-homepage/76203/good-stories-consular-support-eu-citizens-stranded-abroad_en
 15. <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=424AC0000000031>.
 16. <https://www.fdma.go.jp/laws/tutatsu/items/0316jimumennraku.pdf>.
 17. Шинэ төрлийн коронавирусын халдварын бэлэн байдалд зэрэгт шилжсэн нөхцөл байдлын талаарх тайлан, https://corona.go.jp/news/pdf/kinkyujitaisengen_houkoku0604.pdf.

18. https://www.jda.or.jp/dentist/coronavirus/upd/file/20200413_coronavirus_kinkyujitaisengen_kihontekitaisyohousin49.pdf
19. 志田陽子「緊急事態宣言と「集会の自由」—— 「表現の自由」のために今「自粛」を呼びかける理由」(<https://news.yahoo.co.jp/byline/shidayoko/20200407-00171865/>)
20. <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=424AC0000000031>
21. <http://www.yama-ben.jp/statement/1290/>
22. Япон улсын Өмгөөлөгчдийн холбооноос хуулийн төсөлд өгсөн санал, 2012 оны 3 дугаар сарын 9.
23. <https://www.nichibenren.or.jp/document/statement/year/2012/120322.html>, Яаманаши мужийн Өмгөөлөгчдийн холбоо, 2020 оны 3 дугаар сарын 17, <http://www.yama-ben.jp/statement/1290/>.
24. https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000121431_00098.html.
25. Япон улсын Цагаачлалын агентлагаас хуулийн 61 дүгээр зүйлийн тайлбар, <http://www.immi-moj.go.jp/tetuduki/kanri/kikoku.html>.
26. <https://www.worldometers.info/coronavirus/>.

ХАВСРАЛТ

Гадаадад байгаа иргэдэд тулгамдаж буй асуудал

Энэ хэсэгт Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын хилээр зорчих хөдөлгөөнийг хязгаарласан хугацаанд гадаадад байгаа иргэдэд ямар асуудал, эрсдэл үүсээд буй талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Доорх асуудлыг шийдвэрлэх зорилгоор УОК-оос 2020 оны 12 дугаар сард 3 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэхээр төлөвлөж байснаас УБ-Франкфурт болон УБ-Токио чиглэлд тусгай үүргийн нислэг үйлдсэн. Гэвч дотоодод халдварын тоо нэмэгдэж байгаагаас шалтгаалж тусгаарлах байрны хүрэлцээ хангалтгүй байгаатай холбоотойгоор Улаанбаатар-Сөүл чиглэлийн нислэгийг цуцалсан байна⁷⁰. Энэ асуудлаар Хүний эрхийн үндэсний комиссоос 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүний эрх, эрх чөлөөний зөрчлийг таслан зогсоох, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор УОК-ын даргад шаардлага хүргүүлжээ⁷¹.

Тайлбар

Канад Улсын Ванкувэр хотод түр оршин суугч М.А: “Одоогоор Канад Улсын Ванкувэр хотод түр оршин сууж байна. 2 сарын сүүлээр буцах төлөвлөгөөтэй байсан боловч боломжгүй байсаар өнөөдрийг хүрсэн. Элчин сайдын яамандаа буцах хүсэлтээ 3 сарын дундуур өгсөн. Би УОК-оос тавьсан шалгуурт тэнцэхгүйгээ мэдсэн. Тэглээ гээд эх орон руугаа буцах шаардлагагүй гэсэн үг биш шүү дээ. Энд аяллаар ирсэн. Виз дуусаж дахин мэдүүлээд явж байна. Үр хүүхдүүд, гэр орон минь монголд байна. Энэ хамгийн том шалтгаан биш гэж үү? Манай энд ямар нэг шинж тэмдэггүй хүнд шинжилгээ хийхгүй байгаа энэ талаар элчин сайдын яам мэдэж байгаа ч бидэнд яах талаар зөвлөсөн зүйлгүй маш учир битүүлэг хариу өгч байгаа. Мөн 5 шалгуурт тохирохгүй бол буцах боломжгүй гэж ойлгоод байгаа”.

⁷⁰ Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Л.Мөнхтүшигийн ЭМЯ-ны ээлжит хэвлэлийн хуралд өгсөн мэдээлэл, (<http://itoim.mn/article/uJtnd/25008>)

⁷¹ 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүний шаардлага, Дугаар 5/29

Австрали Улс руу аялсан иргэн Г.Б: “Би Австралиас УОК-ын 18001105 утас руу залгалаа. Солонгос, Орос зэрэг цөөхөн улс орнуудаас бусад улс орон COVID 19 шинжилгээг амар өгөх боломжгүй. Тусгай шалгууртай, Солонгост очоод өгөхийн тулд 14 хоногийн карантинд орох шаардлагатай. Зарим хотоос Сөүл орох хүмүүс нь 48 цаг замдаа хэд дамжиж очиж байна гэж гомдол гаргасан юм. Гэтэл утас авсан хүн нь “Сөүлийн онгоц дүүрсэн, өмнөх 2 нислэгт орж чадаагүй хүмүүсээр дүүрсэн, битгий дэмий Сөүлд очоорой” гэж хэлсэн.

БНСУ-д эмчлүүлэгч Ч.С: “Би Солонгост яахаа мэдэхгүй байдалд орчхоод байна. 61 настай. Ядахдаа өөртөө таарсан ажил хийе гэхээр хөгшин гээд авахгүй юм. Яаралтай эх орондоо очих юмсан. Эмчилгээнд ирсэн боловч эмнэлэг маань хүлээн авах боломжгүй болсон. Ингээд наашаа ч үгүй, цаашаа ч үгүй гацчихаад байна”.

АНУ-д суралцаж буй оюутан А.С: “Сургууль маань 3 сараас онлайн хөтөлбөрт шилжээд оюутнуудад нутагтаа харьж болно, онлайнаар шалгалтаа өгөөд төгсөх боломжтой гэсэн. Гэтэл бидэнд одоогоор ямар ч буцах боломж байхгүй байгааг бүгд мэдэж байгаа. Одоо гадаадад байгаа монголчууд бүгд эрсдэл дунд байна. Түүр хугацаанд ирсэн хүмүүс, оюутнууд, эсвэл ээж аав үр хүүхдэдээ буцмаар байгаа хүмүүс зөндөө. Зарим нь эхнээсээ мөнгөгүй, байргүй, хоолгүй хүнд нөхцөлд орж байгаа. Энд Ази гэж ялгаварлан гадуурхагдаагүй байж, Монголд байгаа зарим хүнд гадаадад байгаа гэдгээрээ ялгаварлан гадуурхагдаж, үзэн ядагдаж байгаа нь үнэхээр эмгэнэлтэй санагдаж байна. Бүх улс иргэдээ буцаан авч байна. Бид ч бас нутагтаа буцах эрхтэй”.

Чех Улсад гацсан иргэн Б.Э: “Би Чех Улсад амьдардаг. Удаа дараа хүсэлтээ өгч байгаа. Хариу өгөөгүй л байна. Тэр битгий хэл тусгай үүргийн онгоц Франкфуртэд ирэх болсныг манай элчин сайдын яам мэдээгүй байсан. Хүмүүсийн хэлж байгаагаар тэр онгоцонд арын хаалгатай нь багтдаг юм шиг байна. Онгоцонд суух хүний нэрс аль хэдийн тодорхой болчихсон, суудал нь дүүрчихсэн гээд ярьж байна лээ. Гэтэл энд хоногийн хоолны мөнгөгүй, хоноглох газаргүй олон хүн горьдон хүлээж байна. Тусгай үүргийн онгоцны арын хаалгаа хааж өгөөч дарга нар минь”⁷².

⁷² “Гадаадад гацсан монголчуудын “арын хаалга”-тай нь чартер нислэгт багтаж байна”, 2020 оны 4 дүгээр сарын 23, (<http://zuv.mn/n29>).

Аргентин Улсад 3 сар гаруй гацсан Э.Э: “Миний бие одоогоор Аргентин Улсад суугаа юм. Энд их сургуулийнхаа хөтөлбөрийн дагуу 1 сарын 1-нд ирсэн ч одоог болтол эндээс явах боломжгүй гацаад байна. Та бүхний мэдэж байгаа Covid-19 цар тахлын улмаас Монгол Улс хилээ хааж иргэдийнхээ нутаг буцах нөхцөл байдлыг нь хязгаарлаад байгаа билээ. Уг нь байдал хүндэрч байгааг мэдсэн даруйдаа 3 сарын дундуур монгол руугаа буцъя гэх санаа байсан юм. Гэвч онгоцны тийз байхгүй, хил хаалттай байсан учир яах ч аргагүй өнөөдрийг (2020.06.01) хүрээд байна”⁷³.

Тайланд Улсад 4 сар гаруй хугацаанд гацаад буй Б.У: “Миний бие Филиппин Улсад суралцаж байгаад корона вирусийн цар тахал дэгдэж транзит нислэгээр эх орондоо очихоор Тайландад ирсэн ч цааш явах боломжгүй болсон. Учир нь Тайландаас ОХУ, ОХУ-аас Монгол руу буцах ганцхан боломж байсан ч ОХУ хилээ хааснаар ийнхүү гацсан”⁷⁴.

Тайланд Улсад гацсан Г.У: “Би Тайландад ажиллаж, амьдардаг. Ээж маань 1 дүгээр сарын 8-нд ирээд 3 дугаар сарын 26-нд МИАТ-ын шууд нислэгээр буцах байсан. Энэ үед Тайландад арай сэрүүн болдог тул тэр үеийг нь ашиглаж ээжтэйгээ хамт байж, асрах гэж ирүүлсэн юм. Гэтэл нислэг цуцлагдаад хүлээсээр байтал хүндээр өвдчихсэн. Тайландад амьдралын өртөг өндөр. Тэр тусмаа гаднын болон түр байгаа хүмүүст. Тайландад байгаа гадны улсын иргэн түр зуур ажил хийнэ гэсэн ойлголт байдаггүй учраас гацсан хүмүүс бүгд орлогын ямар ч эх үүсвэргүй байгаа. КОВИД анх гарахад зочид буудал, байр түрээсэлдэг эзэд сууж байсан хүмүүсээ хөөж гаргаж байсан. Одоо бол санхүүгийн хүндрэл их гарч байна. Тайландад гацсан хүмүүсээс манай ээж шиг үр хүүхэд, ах дүү дээрээ ирсэн хүн тун цөөхөн. Дийлэнх нь түр хугацаагаар ирсэн бөгөөд одоогоор зочид буудлуудаар л хоног төөрүүлж байгаа. Бас Зүүн өмнөд Азийн бусад оронд байж байгаад КОВИД гарсны дараа Тайландаар дамжин нутаг руугаа явах гэж ирээд, энд гацсан хүмүүс ч бас нэлээд олон бий.

⁷³ “Гадаадад гацсан монголчууд: биелүүлэх ёстой учрал”, 2020 оны дугаар сарын 2, (<https://medium.com/altan-gurgaldai/гадаадад-гацсан-монголчууд-биелүүлэх-ёстой-учрал-298270b2fb5d>).

⁷⁴ “Эгүүрийн сэдэв: Гадаадад гацсан иргэдээ гачлангүй татахыг хүлээсэн 10,600 зүрх”, 2020 оны 7 дугаар сарын 27, (<https://eguур.mn/125516/>).

Бидэнд тулгарч буй бас нэгэн асуудал нь виз сунгуулах. Жишээ нь: 3 сарын сүүлээр манай найз Цагаачлалын төвд визээ сунгуулахаар өглөө 08:00 цагт очиход, дарааллын 1096 дахь дугаар авч байсан”⁷⁵.

Малайзад 5 сар гаруй гацсан А: “Польш руу нисэх замдаа нэг хүн, эх орондоо ирээд хүүхдээ үнсэж ч чадахгүй нас барлаа. Нислэгийн тийз үнэтэйгээс билетийн мөнгөгүй олон хүн үлдлээ. Нислэг хүлээсээр байтал хоол хүнсгүй боллоо. Малайзад нэг хүүхэдтэй эгч тийзийн мөнгөгүйн улмаас үлдсэн. Хаачих юм бүү мэд. Бас нэг 60 настай хүн хэрэглээний мөнгөгүй, идэх хоолгүй гудамжинд сууж байсан. Яг аав шиг минь хүн хүний нутагт хаягдаад идэх хоол, орох оронгүй байгааг хараад их эмзэглэсэн. Тэгээд би өөрт байсан мөнгөнөөсөө илүүчлэн хоол, ус, ундаа авч өгсөн. Тэр хүн цааш хэрхэн амь зогоохыг хэлж мэдэхгүй юм. Зарим нь хүүхдээ тэврээд элчингийн гадаа сууж байгаа. Энэ мэт ирж чадахгүй байгаа хүмүүстээ санаа зовниод байна”⁷⁶.

Хилийн Чанад дахь Монголчуудын Зөвлөл ТББ-ын УЗ, Хөтөлбөр хөгжлийн хорооны дарга Б.Э: “Унгарын Засгийн газрын тэтгэлгээр сурч төгссөн 78 оюутан тэтгэлэг нь зогссон. Мөн нөхцөл байдлаа Унгарын Засгийн газарт уламжилж, тэтгэлгээ үргэлжлүүлэхийг хүссэн ч зөвшөөрөөгүй. Дотуур байрнаас нь гаргаж, оюутнуудын талаарх мэдээллийг Элчин сайдын яаманд мэдээлсэн”⁷⁷.

Япон Улсад гацсан А.Д: “Миний хувьд төгсөх дөхөж байсан болохоор байрнаасаа гарах гэрээгээ хийчихсэн, цагийн ажлаа ч дараагийн хүндээ хүлээлгээд өгчихсэн байсан юм. Тэгээд л 3 сарын 31-нд буцах ёстой байсан би хоёр чемодан дүүрэн ачаа, хичээлийн үүргэвчтэйгээ гудамжинд гарсан. Ажилдаа буцаж орох гэсэн боловч аль хэдийн гэрээ хийгдсэн тул болсонгүй. Өөр ажил хайж үзсэн ч хэдий болтол ажиллах нь тодорхойгүй учраас олдсонгүй. Энэ хугацаанд айлаас айл дамжиж 2 чемоданаа чирээд 5 удаа нүүсэн. Ийм байдалтай 5 сарыг өнгөрөөсний дараа бараг бүх мөнгө маань дууссан”⁷⁸.

⁷⁵ “Т.Уянга: Гадаадад гацсан Монголчууд вирус биш”, 2020 оны 6 дугаар сарын 5, (<http://www.zaluucom.mn/read/4cg1g874a>).

⁷⁶ “Зууны мэдээ” сонин 2020 оны 8 дугаар сарын 3, № 155 (6380).

⁷⁷ “Б.Энхгэрэл: Гадаадад байгаа монголчууд онгоц, тусгаарлах байраа олсон ч УОК зөвшөөрөхгүй байна”, 2020 оны 7 дугаар сарын 10, (<http://npost.mn/a/168737>).

⁷⁸ “Гадаадад гацсан элэг нэгтнүүдээ төлөөлж бичсэн захидал”, 2020 оны <http://posted.mn/c/letter-elegzurhneesuyatai>.

АНУ-д гацсан иргэн Б.У: “Энд тав болон гурван настай хоёр хүүхэдтэйгээ ирсэн. Одоо таван сартай жирэмсэн. Наашаа ирэхдээ хөл хүнд болсноо мэдээгүй байсан. АНУ-д суурин амьдардаггүй, 10 хоногийн хугацаатай ирээд гацсан болохоор хүнд байна. Нэгдүгээр сарын 20-оос хойш дөрвөн сар энд байлаа. Бусад хүмүүстэй харьцуулахад миний нөхцөл байдал гайгүй байсан учир хил нээгдэнэ гэж найдаад тусгай нислэгт бүртгүүлэлгүй хүлээж байсан. Гэтэл нөхцөл байдал улам хүндэрлээ. Ихэнх компани 32-оос дээш долоо хоногтой бол нислэгт оруулахгүй гэсэн дүрэмтэй. Тусгаарлах зардал, онгоцны тийзээс эхлээд маш их асуудал байна. Хилээ хааж, иргэдээ оруулахгүй байгаа орон Монголоос өөр алга. Эх орондоо очих эрхээс эхлээд сонгох, сонгогдох эрхийг минь хүртэл хааж, биднийг гаргуунд нь хаясан төр засагт үнэхээр гомдож байна.”

Энэтхэгт байгаа хүүхдүүдийн ээж Д.Т: “Хүүхдүүд маань хэзээ ирэхийг мэдэхгүй байна. Энэ сарын 29, 30 хавьцаа гэж сонссон ч одоогоор нам гүм байна. Тэнд хоёр хүү маань дунд сургуульд суралцдаг. Гэтэл 2003 онд төрсөн хүүг минь 17 хүрсэн гээд нислэгт багтаагаагүй. Бага хүү маань ганцаараа ирэх бололтой. Манай хоёр хүүгийн байгаа газар 29 хүүхэд тусгай нислэгт бүртгүүлсэн ч 11 хүүхдийн нэрийг л баталсан байсан. Нислэгийн зардал өндөр болохоор ах дүү нараасаа зээл авч, төлнө. Санхүүгийн асуудлаас болоод ирж чадахгүй байгаа маш олон хүүхэд бий. Шашны сургуульд ихэвчлэн амьдралын боломжгүй, бага орлоготой айлын хүүхдүүд суралцдаг. Энэтхэгт халдварын тархалт нэмэгдсээр байна. Хүүхдүүддээ санаа зовж, байнгын айдастай байна.”

БНСУ-д байгаа иргэн Х.И: “Би Солонгост ажил хийдэг. Хүүхдүүдээ улирлын амралтаар нь авч ирсэн. 13-тай, 7 настай, нэг ой 10 сартай гурван хүүхэд маань энд дөрвөн сар гацаж байна. Нэг сар л байна гэж төлөвлөсөн учир олон хүндрэл үүссэн. Ямар ч мэдээлэл өгөлгүй хаасан. Одоо хүүхдүүдээ харахын тулд ажлаасаа гарч, өдөр хоногийг хүлээлгийн байдалтай өнгөрүүлж байна. Гэрээсээ гарахгүй байгаа учир хүүхдүүд хөдөлгөөний дутагдалд орж, дунд хүү маань бүдүүн, нарийн гэдэс нь үрэвсэж, өндөр төлбөртэй хагалгаанд орсон. Энд амьдардаг монголчууд маань тусалж, дэмжиж, Солонгосын эмнэлэгт хүсэлт гаргасны хүчинд хүүхдээ эмчлүүллээ. Транзит нислэгт суух ямар ч мөнгөний боломж алга. Анх төр засагтаа итгэж, тайван хүлээсэн. Гэтэл ингээд хүний нутагт хөсөр хаягдаж байна”⁷⁹.

⁷⁹ “Хүний нутагт гацсан хүүхэд, эхчүүдээ хөсөр хаясан Монголын эмгэнэл” нийтлэл, Засгийн газрын мэдээ сонин, 2020 оны 5 дугаар сарын 28.

2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар эх орондоо нэн яаралтай буцах хүсэлт гаргасан нийт 2,154 иргэн байна. Үүнээс Европ тивээс 647, Ази тивээс 1,113, Австрали тивээс 95, Африк тивд 4, Америк тивд 295 иргэн тус тус байна⁸⁰. Гэвч дотооддоо халдварын тохиолдлууд бүртгэгдэж, бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор тусгай үүргийн нислэгийг тодорхойгүй хугацаагаар зогсоосон нь гадаадад байгаа иргэдийн эх орондоо буцаж эрхийн ноцтой зөрчил юм. Тухайлбал, 11 дүгээр сард төлөвлөсөн байсан тусгай үүргийн бүх нислэгийг гэнэт цуцалсантай холбоотойгоор гадаадад байгаа зарим иргэдэд үүсээд буй асуудал, нөхцөл байдлыг дараах хүснэгтэд үзүүлээ.

⁸⁰ Гадаад харилцааны Консулын газрын захирал Л.Мөнхтүшигийн ЭМЯ-ны хэвлэлийн бага хуралд өгсөн ярилцлага, (https://ikon.mn/n/225s?fbclid=IwAR2VTzMiYFem5M6mEgjily_0h_flj-b4quv8hrt2F91h-uxFejcthyYXR2c)

Сөүл

Чүнбүг Үндэсний их сургуулийн магистрант Б.Я: “11 дүгээр сарын 12-ны онгоцоор нутаг буцахаар онгоцны билетээ авсан хоёр нислэгийн тус бүр 160, нийт 320 хүн бий. Буцна гээд Солонгос дахь ажил, хичээл сургууль бүх зүйлээ зохицуулж, амьдарч байсан байрнаасаа гарсан хүмүүс хүнд нөхцөлд 17-18 хонож байна. Бүх мөнгөө шавхаж онгоцны тийз, тусгаарлах байрны төлбөрөө хийсэн оюутан надад үнэндээ амаргүй байна. Хичээлийнхээ хажуугаар ажил хийж байж энэ зардлаа гаргасан шүү дээ. Хэзээ явахаа мэдэхгүй би байрны төлбөрөө өдөр өдрөөр нь тооцон төлж байна. Өнөө маргаашгүй нисэх гэж байсан бидний хувьд ачаа тээш, мөнгө төгрөгөө Солонгост байх хоногтоо тааруулаад төлөвлөсөн байсан. Би л гэхэд бүх ачаагаа явуулчихсан, өмссөн хувцас, нөүтбүүктэйгээ л үлдсэн. Одоо Солонгост хүйтэн болж байна. Амьдарч байгаа байрнаасаа гарсан, мөнгө төгрөгөө шавхсан иргэд зочид буудал, нийтийн халуун усны газар, гудамжинд ч хоног төөрүүлж, маш хүнд нөхцөлд байна. Нутаг буцахаар мөнгөө шавхсан бидэнд цагийн ажил ч олдохгүй болсон”⁸¹.

Л.М: “Сөүл Улаанбаатарын 11 дүгээр сарын 12-ны өдрийн нислэгээр Монгол руу буцах гэж байсан ч гэнэт шийдвэр гарч цуцлагдсан. Эх орон руугаа буцах бүх бэлтгэлээ хангаж эндэх ажлаа зохицуулаад байрлаж байсан байрнаасаа гарч, ажлаа хүлээлгэж өгсөн. Одоо орох оронгүй, очих газаргүй үнэхээр хүнд байдалтай байна. 11 сарын 12-ны нислэгт хамрагдсан хүмүүс дунд жирэмсэн эх болон хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай хүмүүс олон. Жишээ нь, 5 болон 7 сартай эх хүн, Монголд ар гэрт нь ажил явдал гараад хүүхдүүд дээрээ яаралтай очих зэрэг хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаантай хүмүүс олон байна. Миний хувьд байр, ажлаа хүлээлгэж өгсөн болохоор найзындаа түр байрлаж байгаа. Дахиад хөлслөх байр хайя гэхээд барьцааны мөнгөгүй. Би бага насны хүүхэдтэй, жирэмсэн. Манай гэр бүл эх орондоо очихын тулд зөвхөн замын зардалд гэхэд 7,2 сая төгрөг зарцуулсан. Бүх зүйлээ төлөвлөж хүлээж байхад шууд ингээд тодорхой бус хугацаагаар хойшлуулахаар үнэхээр хүнд байна”⁸².

⁸¹ “Сөүлээс энэ сарын 11, 12-нд ирэх байсан иргэд зочид буудал, халуун усны газраар хоноглож, хүнд нөхцөлд байна”, 2020 оны 11 дүгээр сарын 28, https://gogo.mn/r/nd7w2?fbclid=IwAR0UcQjGjsyY2JaCj1kCnobmAgMEH1NjRtAMQ_MMaKsrX1_vhB_gpyNK12Y.

⁸² “Зууны мэдээ” сонин 2020.11.20 № 223 (6448).

Франкфурт

Г.М: “Европын 28 оронд амьдарч, ажилладаг иргэд Германд ирж, 11 сарын 19-ний нислэгээр Монгол руугаа буцахаар төлөвлөж байсан. Гэтэл нислэг цуцлагдаж иргэд маш хүнд нөхцөлд үлдсэн. Анх цар тахал гарч хилийн хорио тавигдсан цагаас буюу 10 сар орчим хүлээсэн иргэд ихэнх хувийг нь эзэлж байна. Зөвхөн 11 сарын 19-ний онгоцоор 250 гаруй иргэн, үүнээс гадна хүсэлтээ өгөөд чартер нислэгт багтаж чадаагүй олон зуун иргэн байгаа. Эдгээр иргэдийн дотор бага насны хүүхдүүдээс гадна өндөр настан, жирэмсэн, эрүүл мэндийн маш ноцтой шалтгаантай хүмүүс, оюутнууд, асран хамгаалагчгүй ганцаараа яваа 16 настай охин болон бусад хүндэтгэх шалтгаантай хүмүүс байна. Монгол руугаа буцах хүсэлтэй иргэд энд хийж байсан ажил болон гэрээнүүдээ бүгдийг нь цуцлаад, эх орон руугаа явахаар төлөвлөчихсөн байсан ч хэдхэн хоногийн өмнө цагийг нь тулгаж нислэг цуцалсан. Өвлийн хүйтэнд эхнээсээ гудамжинд хонох дээрээ тулаад байна. Европын холбооны улсууд гэрээ хэлэлцээр, хууль дүрмийг чанд баримталдаг учраас буцаад богино хугацаанд хоноглох байр болон хийх ажил олно гэдэг маш хэцүү. Нислэгийн зардал болон Монголдоо очоод тусгаарлагдах байрны төлбөрт бүх мөнгөө шавхаад төлчихсөн хүмүүс санхүүгийн хувьд ч маш том асуудалд орсон”⁸³.

(Нэр дурдагдаагүй): “Австри Улсад 3 сарын дунд үеэс 5 сарын сүүл хүртэл бараг хоёр сар гаруй хатуу хөл хорио тогтоосон. Тухайн үед Монгол руугаа явах хүсэлтэй байсан ч тусгаарлалт болон тусгай үүргийн онгоцны билетийн мөнгөгүйн улмаас эндээ үлдэхээс өөр аргагүй болсон юм. Эх орон руугаа буцах нислэгийн төлбөрийг цуглуулахын тулд ресторанд ажиллаж эхэлсэн ч хөл хорионы улмаас 3 сард хаагдсан. Тиймээс айлд цэвэрлэгээ хийн байж нислэгийн мөнгөө цуглуулж дуусаад 10 сард нутаг буцах хүсэлтээ өгч, “11 дүгээр сарын нислэгт багтсан” гэсэн мэдээг дуулаад маш их баярлаж байсан ч нислэг цуцлагдсан. Бидний ихэнх нь оршин буй газраасаа Франкфурт хүртэлх нислэгээ буцаах боломжгүй, хатуу нөхцөлтэйгөөр захиалсан тул нэг хүн багадаа сая гаруй төгрөгийн хохирол амсахад хүрээд байна. Мөн Франкфурт явах билетийн 1 сая гаруй төгрөг, Франкфуртээс Улаанбаатар хүртэлх МИАТ-ийн билетийн 3 сая орчим төгрөг болон Монголд очоод тусгаарлагдах сая төгрөг гээд нийлээд Европоос буцаж байгаа нэг хүнээс багадаа 5 сая гаруй төгрөгийн зардал гарсан байгаа.

⁸³ “Г.Мөнхшатар: Гадаадад хоноглох газаргүй, хоол ундгүй яваа олон монгол иргэн тусгай нислэг ирэхийг хүлээж байна”, 2020 оны 12 дугаар сарын 5, (http://itoim.mn/article/BXd3Q/24780?fbclid=IwAR17i6i-vdB1FGMlqSUMAB2mXsa5qhtdq_thsEx_xLzk7dq2fYw6F54az1o).

Энэ бүх зардлыг бидний ихэнх нь аль хэдийн төлсөн, одоо энэ мөнгөнүүдээ буцаагаад авбал нислэгээс хасагдах аюултай тул бид халаас хоосон, орох оронгүй чартер нислэгээ хэзээ ирэх бол гэж хүлээхээс өөр аргагүй байдалд хүрчихлээ”⁸⁴.

Ц.О: “Миний хувьд энэ сарын 18-нд амьдарч байсан байраа хүлээлгэж өгөхөөр тохирсон байсан юм. Гэтэл нислэгийг цуцалчихлаа. Цар тахлын улмаас хатуу хөл хорио тогтоож, айлууд зочин хүлээж авахаа больсон, зочид буудлууд хаалгаа барьсан тул бид хонох газаргүй болсон. МИАТ компанийн зүгээс нэгэнт шилжүүлчихсэн билетийн төлбөрийг богино хугацаанд буцаан олгох боломжгүй гэсэн хариу өгсөн. Транзит нислэгийн хувьд билет буцаах ямар ч боломжгүй. Нэг хүний төлбөр 5,652,000, хоёр хүнийх 10,130,400 төгрөг болсон. Бусад орон ч мөн адил дүнтэй. Үүн дээр транзит нислэгийн 588,000 төгрөг нэмэгдэнэ. Буцах хүсэлтээ өгч, хүлээж байх хугацаандаа зардлаа олох гэж олдсон ажлыг хийж өдийг хүрсэн”⁸⁵.

Герман Улсад гацсан иргэн А.Д: “Би Герман Улсын Дьуселдорф хотод 70 настай эмээтэйгээ хамт амьдардаг. Эмээ маань өнгөрсөн 2 дугаар сард Швейцар луу төрсөн охин дээрээ очихоор 3 сарын хугацаатай явсан. Гэвч тэндээ гацаж эх орондоо буцаж чадахгүй байсан бөгөөд 11 сарын 19-ний нислэгт багтаж Швейцараас Монгол руу буцахаар болсон ч Франкфуртын нислэг цуцлагдаж энд дахин гацсан. Эмээгийн маань визний хугацаа 12 сарын 5-нд дуусна, 2 сараас хойш аль хэдийнээ 3 удаа визээ сунгуулчихсан тул дахиж сунгуулах боломжгүй болсон. Ингээд тэдний зүгээс бидэнд яаж ийж байгаад нутаг буц, эсвэл өндөр торгууль ногдуулна гэж хэлсэн. Эмээг маань Монгол руу буцаахаар Швейцарт байх үеэс хойш олон удаа УОК болон элчин сайдын яаманд хандсан ч ямар нэг хариу өгч байгаагүй. Эмээ маань үе мөчний өвчтэй, Германд амьдрах зөвшөөрөлгүй учраас эмнэлэгт ч үзүүлж чадахгүй хэцүү байна”⁸⁶.

⁸⁴ “Гадаадад гацсан иргэд: Монгол буцах гээд байраа хүлээлгэн өгч, ажлаасаа гарсан иргэд халаасандаа сохор зоосгүй гудамжинд гарахад хүрээд байна”, 2020 оны 11 дүгээр сарын 17, (<http://isee.mn/n/15579>).

⁸⁵ “Тусгай үүргийн нислэгүүд цуцлагдаж, гадаадад гацсан 3800 иргэнээ яах вэ”, Зууны мэдээ сонин, 2020 оны 11 дүгээр сарын 20, (<http://www.zms.mn/a/81677>).

⁸⁶ “70 настай эмээтэйгээ ХБНГУ-ын оюутны байранд гацаад буй А.Долгорсүрэн манай редакцид хандлаа”, 2020 оны 11 дүгээр сарын 23, <https://eguur.mn/155627/>).

Швед Улсын Стокгольм хотод гацсан иргэн Б.Т: “Би эхнэр хоёр хүүхдийн хамт амьдардаг. Миний гэрээний хугацаа дуусаж, гэр бүлээрээ эх орон руугаа буцах хүсэлтэй байна. Бид энэ хүсэлтээ өнгөрсөн 8 сард Элчин сайдын яаманд өгч, 11 сарын 19-ний тусгай үүргийн нислэгт багтахар болсон юм. Гэвч Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос дотоодод халдвар гарсны улмаас тусгай үүргийн нислэгийг тодорхойгүй хугацаагаар хойшлуулж, бид маш хүнд байдалд ороод байна. Дамжин суух болон тусгай үүргийн онгоцны билетүүдээ бүгдийг захиалсан байсан. Бид 2 хүүхэдтэй. Том нь 2 настай, бага нь 5 сартай. Бид 11 сарын 12-нд чартер нислэгийн билетээ худалдан авсан. Нэг хүний 2.8 сая төгрөг, 0-3 насны хүүхэд үнэ төлбөргүй гэсэн хэр нь 2 настай охин маань нэг сая гаруй төгрөгөөр тасалбар авсан. Бид Элчин сайдын яамандаа хандахад “Бид материаллаг эд зүйлсээр тусалж чадахгүй. Засгийн газар, Улсын онцгой комисс, Гадаад харилцааны яаманд нөхцөл байдлыг уламжилж өгье. Бид Улсын онцгой комиссоос ямар шийдвэр гарахыг хүлээж байна” гэдэг хариултыг өгсөн. Бид гэр бүлээрээ танил айлд түр байрлаж байна. Миний хувьд 11 сарын 19-нд Монгол руу буцна гээд ажлаасаа гарч, байраа хүлээлгэн өгсөн. Одоо манай гэр бүл дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болчихоод байна”⁸⁷.

Англи Улсад гацсан иргэн У.А: “Би 3 сард Монгол руу буцах хүсэлтээ анх өгөөд эцэст нь 11 сарын Франкфуртын нислэгт багтсан байсан ч Англи улсад гацчихаад байна. Коронавирусийн 2 дахь давлагаа үүссэн гээд ажил олдохгүй, байраа хүлээлгээд өгчихсөн, өмнө нь цуглуулсан бүх мөнгөө энэ хэдэн сард байрны мөнгө, хоол хүнсэндээ төлөөд дуусчихсан. Айлд очиж болохгүй хэрвээ айлд очвол торгууль ногдуулна, гэхдээ ажилгүй, очих газаргүй болохоор өмнө нь амьдарч байсан айлдаа ирчхээд байгаа. Хэрвээ хөрш айлуудаас энэ талаар гомдол, мэдээлэл өгвөл өндөр үнийн дүнтэй торгууль ирнэ, үнэхээр хэцүү байна”⁸⁸.

⁸⁷ “Шведэд Монгол руу буцах хүсэлтэй 50 хүн маш хүнд нөхцөлд байна”, 2020 оны 11 дүгээр сарын 23, (<https://news.mn/r/2375558/>).

⁸⁸ “LIVE: Монгол буцах гээд байраа хүлээлгэн өгсөн иргэд халаасандаа сохор зоосгүй гудамжинд гарахад хүрээд байна”, 2020 оны 11 дүгээр сарын 23, (<https://livetv.mn/p/268561?fbclid=IwAR1mjLAW1pBGGX9iivCiCRIjzeVSUWydAiM2XZe5yOUTtF1UM3z97Gtt5Yw>).

